

**МОНГОЛ УЛСААС ТӨВ БОЛОН ДОРНОД ЕВРОПЫН
ОРНУУДАЙ ДИПЛОМАТ ХАРИЛЦАА ТОГТООСНЫ
55 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛСАН ДУГУЙ
ШИРЭЭНИЙ УУЛЗАЛТ**

**УУЛЗАЛТЫГ НЭЭЖ ГАДААД ХЭРГИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Р.АЛТАНГЭРЭЛИЙН ХЭЛСЭН ҮГ**

Эрхэмсэг ноён элчин сайд нараа, энд хуран цугласан хатагтай ноёдоо! Та бүхэнд энэ өдрийн амгаланг айлтгая.

БНПУ, БНБУ, БНЧУ, БНСУ, БНУУ, БНРУ зэрэг Төв болон Зүүн Европын улс орнуудтай Монгол Улс дипломат харилцаа тогтоосны 55 жилийн ойд зориулан хийж буй энэ дугуй ширээний уулзалтанд оролцож байгаа та бүхэнл Монгол Улсын Гадаад хэргийн Сайд, УИХ-ын гишүүн Мөнх-Оргилын чин сэтгэлийн мэндчилгээг дэвшүүлж, дугуй ширээний уулзалтын үйл ажиллагаанд амжилт хүссэнийг уламжлахыг зөвшөөрнө үү.

Одоогоос 55 жилийн өмнө 1950 оны 4-р сард Монгол Улс Зүүн Европын эдгээр улсын хооронд дипломат харилцаа тогтоосон билээ. Польш улстай 4-р сарын 14-нд, Болгар улстай 4-р сарын 22-нд, Чех болон Словак улстай 4-р сарын 25-нд, Унгар улстай 4-р сарын 28-нд, Румын улстай 4-р сарын 29-нд албан ёсны харилцааны эхлэл тавигдсан байна.

1950-иад оны үе бол манай орны хувьд олон улсын тавцанд гарч тусгаар тогтносон бүрэн эрхт улс гэдгээ дэлхийн улс гүрнүүдээр хүлээн зөвшөөрүүлэхийн төлөө ид тэмцэж байсан цаг үе билээ. Чухам энэ үед дээр дурдсан орнууд манай улсыг хүлээн зөвшөөрч албан ёсны дипломат харилцаа тогтоосон нь өнөөдрийн өндөрлөгөөс эргэн харахад Монгол орны олон улсын нэр хүндийг өсгөх, дэлхийн хамтын нийгэмлэгт зүй ёсны байр сууриа эзлэхэд нь үзүүлсэн томоохон дэмжлэг, чухал түлхэц байсныг энэ өдөр талархан тэмдэглэх учиртай биз ээ. 1950-1990-ээд он хүртэл Монгол Улс эдгээр оронтой тухайн үеийн гадаад бодлогын зарчимд нийцүүлэн бүх талын харилцаа, хамтын ажиллагаагаа эрчимтэй хөгжүүлж байсныг түүх гэрчилнэ. Түүхэн хөгжлээ эргэн харвал Монгол Улс Зүүн Европын эдгээр орнуудтай 1950-иад оны эхэн үеэс эдийн засаг, худалдаа, соёл, боловсрол, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар сайхан амжилтанд хүрч байсан. Үүний ганц жишээг дурдахад манай улс 1955 оноос эхлэн Европын эдгээр орнууд руу оюутан залуучуудаа суралцуулж, дээд боловсролтой

1500 гаруй мэргэжилтэн улс ардын аж ахуйн бүх салбарт бэлтгэсэн байна. 1990-ээд он хүртэлх манай гадаад харилцаанд эдгээр орнуудтай амжилттай хамтран ажиллаж ирсэн нь нэрийн хуудас гэж сэтгэл дүүрэн хэлэх олон арван үйлдвэрийн газар, соёл боловсрол, шинжлэх ухааны харилцааны үр шим болсон тоо баримтууд элбэг байдаг билээ. Монгол Улс эдгээр улсуудын хоорондын уламжлалт найрсаг харилцаа, хамтын ажиллагаа эдүгээ он цагийн сорилт шалгуурыг амжилттай даван туулж хоёр талын хүчин чармайлтын үрээр амжилттай сэргэн идэвхжиж, ардчилал, зах зээлийн үндсэн зарчимд тулгуурлан шинэ агуулга хэлбэрээр баяжин бүх салбарыг хамран идэвхитэй хөгжиж байна.

Эцэст нь онцлон тэмдэглэхэд Төв болон Зүүн Европын эдгээр улс орнууд Монгол Улсын гадаад бодлогод чухал байр суурь эзэлсэн хэвээр бөгөөд өнөөдөр ч бидний дотны анд итгэлтэй түнш хэвээр байгаа билээ. Ялангуяа Польш, Унгар, Чех, Словак зэрэг манай уламжлалт харилцаатай орнууд Монгол Улсын өнөөгийн гадаад бодлогод нэн чухал байр суурь бүхий Европын Холбооны бүрэн эрхт гишүүн болсон явдал бидний хамтын ажиллагааны боломжийг улам өргөтгөж байгаа төдийгүй Монгол Улсын гадаад бодлогын үйл ажиллагааны орон зайг тэлж байгаа сайхан үйл явдал гэдгийг тэмдэглэн хэлэхэд таатай байна. БНПУ, Болгар, Чех, Словак, Унгар, Румын улстай манай улс дипломат харилцаа тогтоосны 55 жилийн ойд зориулан хийж байгаа өнөөдрийн энэ дугуй ширээний уулзалтанд дахин амжилт хүсэж та бүхэнд сайн сайхныг хүсэн ерөөе.

Анхаарал тавьсанд баярлалаа.

MONGOLIA AND CENTRAL, EASTERN EUROPE

*Л.Оюунгэрэл**

Today we are celebrating the 55-th Anniversary of the establishment of diplomatic relations between Mongolia and Bulgaria, Czech, Hungary, Poland, Romania and Slovakia. Just after WW II this event was very important for Mongolia to strengthen his independence and international recognition in Europe. Central and Eastern Europe countries were among first countries to support Mongolia in joining the United Nations.

Despite the illusions of socialist objectives and inefficacy of its economic principles the relationships and economic cooperation of Mongolia with former socialist countries of Central and Eastern Europe considering in the large context of civilizational development were advantageous for Mongolia. During 1950-1990s nomadic Mongolia became a contemporary country with developed industries and highly qualified human resources. First professional workers were trained with the assistance of East European countries who worked in the factories constructed with the assistance of these countries. Mongolian people still remember that with technical assistance of Bulgaria were created such industries as: Meat Combine in Choibalsan, Darkhan fur factory, and experimental fruit and vegetables farm in Orkhon and Sharyn-gol, built with technical assistance of Bulgaria, leather and shoes factories in Ulaanbaatar, hospital and Cement factory in Darkhan constructed with the assistance of Czechoslovakia, Bio-Combine in Songin, Meat processing plant in Darkhan, Station of medical plantes in Honhor, Flour Mill in Harhorin, built with technical assistance of Hungary, Wood working combine, built with assistance of Poland, and Building of State Circus and Furniture factory built with the assistance of Romania.

During the 1990s most of these plants were closed down and workers faced a new challenging situation of market economy. Today a number of these workers find their jobs in South Korea and a few of them - in Hungary or other countries. It may be said they are showed the effectiveness of investment in human resources. All these workers working abroad support a considerable number of household's lives, reducing the level of poverty in Mongolia.

Due to the difficulties of transition period from the bureacratc administrative mode of regulation to market economy in these years the relationships of Mongolia and Central and East European countries come

Л.Оюунгэрэл - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

to a decline. But mid 90-th thanks to the efforts of both sides the relationships of Mongolia with Bulgaria, Czech, Hungary and Poland were restored and new principles of relationships in the conditions of globalization were reflected in a number of agreements signed between our countries. The visits of Presidents of Hungary and of Bulgaria to Mongolia in 1994 and 1995, the visits of President of Mongolia to Hungary in 1995, to Czech and to Poland in 1999, to Bulgaria in 2000 and visits of Parliament of our countries, also visits in Mongolia of Foreign Ministers of Czech in 1999, and of Poland in 2004 and other visits of both sides were important to develop the commercial and economic relations to sign new agreements in the field of education and cultural relationships.

In 1993 the Intergovernmental Commission on commerce, economic and science technic cooperation between Mongolia and Bulgaria was reorganized, also in 1994 an Intergovernmental Commission between Mongolia and Hungary was created. In 2003 first meeting of the Intergovernmental Commission between Mongolia and Czech was held. In 2005 an Agreement on Economic cooperation between Governments of Mongolia and Republic of Czech was signed.

An example for advanced step in the elaboration of new judicial principles of relationships between our countries was a Commercial Agreement signed between Mongolia and Czech in 1995 and a Treaty on ' Friendly relations and cooperation, signed in 1998 between Mongolia and Hungary.

The work is underway to develop a new legal framework of cooperation between Mongolia and Poland. There is no doubt that the recent visit to Mongolia of the Minister of Foreign Affairs of Poland will contribute to this process. Mongolian and Polish soldiers and commanders are working in a team for the democracy and peaceful renovation of Iraq. It is also a new form of collaboration between our countries in the sphere of maintaining security.

The problems of debts between our countries are successfully regulated with Czech in 2002 and with Poland in 2003.

The efforts have been made to restore the legal principles of the relationships between Mongolia and Romania and Slovakia.

And now, in the beginning of a new century we must answer to the question: what are the potentials to broaden the commercial and economic cooperation between our countries in the conditions of globalization and mainly when Asian countries continue become an important economic force.

Mongolia and Central and East European countries have all possibilities to connect Europe and Asia in the global market, as well as development of political culture of democracy of European origin. In Mongolia more than 1500 people graduated from Universities of Bulgaria, Czech, Hungary, Poland, Romania and Slovakia and speak these rare foreign languages. We may utilise more largely these human resources. We also know that East European Mongolian studies were in previous years very strong.

We must say that commercial relations between our countries still restricted after 90 years. By 2000 the export from Mongolia still unutilized potential and only the import to Mongolia is between 5 million dollars (Poland) to 1,7 million dollars (Hungary). The recent decision of the European Commission to exempt Mongolian goods from the customs duties will enable more favorable conditions to extend Mongolian-Central and East European commercial relations. Mongolia and East european countries may produce jointly ecological products of agriculture in Mongolia and sell in European markets.

But we must emphasise that the investments from East Europe to Mongolia grow up in 1990-2003. The investments of Bulgaria constitute 3.1 percent of all foreign investments to Mongolia or 27, 215 thousands of US \$, and Czech - 4,580 thousands of US \$, and Poland - 1,764 thousands of US \$ and Hungary - 1,100 thousands of US \$. Today there are 75 companies of East European countries are working in Mongolia, total sum of their investments to Mongolia constitutes 34 millions of US \$.

I'd like to emphasize two main fields of deepening the relationships between Mongolia and East Europe. Firstly, bilateral commercial and economic relationships between Mongolia and East european countries may be better developed in five priority fields of the development of Mongolia: livestock, mining, tourism, textile and wood industries. Mongolia has raw materials for the textile and leather industries. Livestock still main source of income to the Mongolian economy. During economic transition - number of professional herders doubled. In 2003, 25 % of exports derived from agriculture. East european countries may make a contribution to the sustainable industrial development of Mongolia - main way of participating Mongolia in the economic integration.

Secondly, Our countries can more largely utilize multilateral cooperation, which is opened with the expansion of the European Union. For example, Hungary and Czech are now subjects of official development assistance to Mongolia. The relationships between our countries may represent an important framework for the relationships between EU and

North East Asia. We must utilize all resources opened by the new, ALA Programme of EU and especially the programme 'Asia-Invest' with the objective to develop small and medium size business in the countries of Asia, to link them with European partners, to introduce know-how, to create a network of Asian intermediaries. It is agreeable to notice today with optimism the future opportunities and potentials of the relationships between Mongolia and Bulgaria, Czech, Hungary, Poland, Romania and Slovakia.

МОНГОЛ УЛС ДОРНОД ЕВРОПЫН УЛСУУДТАЙ ХАРИЛЦСАН ГОЛ ҮЙЛ ЯВДЛЫН ЖАГСААЛТ

Монгол-Болгарын харилцаа

1950 он 4 сарын 22-нд	Хоёр улс дипломат харилцаа тогтоож, 1961 онд ЭСЯ-даа нээсэн.
1957, 1964, 1970, 1979, 1982, 1987 онд	Монголын төр, засгийн тэргүүн нар Болгарт айлчилсан.
1957, 1967, 1973, 1977, 1985 онд	Болгарын төр засгийн тэргүүн нар Монголд айлчилсан.
1967 он	Хоёр улсын хооронд Найрамдал, хамтын ажиллагааны гэрээ байгуулжээ. Уг гэрээг 1987, 1995 онд шинэчилж Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны гэрээ байгуулав.
1994 он	Монгол, Болгарын худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан техникийн талаар хамтран ажиллах Засгийн газар хоорондын комиссыг шинэчлэн зохион байгуулж (1993) анхны хуралдааныг Улаанбаатарт хийв.
1995 он	Болгарын Ерөнхийлөгч Ж.Желев Монголд айлчлав.
1997 он	МУИС, Софийн их сургууль хамтран ажиллах баримт бичгүүдийг байгуулав.
2000 он	Ерөнхийлөгч Н. Багабанди БНБУ-д айлчлав.
2002 оны 2 сар	БНБУ-ын Элчин Сайд Николай Марин Монгол Улсын Ерөнхийлөгчид итгэмжлэх жуух бичгээ гардуулав.
2002 оны 4 сард	Хоёр улсын Шинжлэх ухааны Академи хооронд 2002-2005 онд хамтран ажиллах төлөвлөгөө байгуулав.
2002 он	Болгарын Ардын Хурлын депутат Р.Илиевски тэргүүтэй Болгар, Монголын парламентын бүлэг байгуулав.

2002 оны 6 сард	Монгол Улсын Ерөнхийлөгч Болгар Улсын Ерөнхий сайдтай Кран Монтанад уулзав.
2002 оны 9 сард	Монгол Улсын Ерөнхийлөгч ӨАБНУ-ын Йоханнесбург хотод болсон дэлхийн дээд хэмжээний уулзалтын үеэр Болгар Улсын Ерөнхийлөгчтэй уулзав.
2002 оны 9 сард	Монгол Улсын Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун НҮБ-ын 57 дугаар чуулга уулзалтын үеэр Болгарын Гадаад хэргийн сайд Соломон Пасси нар уулзав.
2002 оны 9 сард	Болгарын Үндэсний телевизийн дарга Кирилл Гоцев тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад айлчлав.
2002 оны 12 сард	Болгарын Ардын Хурлын дарга Огнян Герджиков тэргүүтэй төлөөлөгчид Монголд айлчлав.
2003 оны 2 сарын 18-19-нд	Монгол, Болгарын Засгийн газар хоорондын Комиссын II хуралдааныг Монгол Улсын Байгаль орчны сайд У.Барсболд, Болгарын Эдийн засгийн дэд сайд Никола Янков нар тэргүүлж Софи хотноо хуралдуулав.
2003 оны 2 сарын 18-нд	Монгол Улсын Байгаль орчны сайд У.Барсболд, Болгарын Байгаль орчин, усны сайд хатагтай Д.Арсенова нар Софи хотноо уулзаж хоёр улсын Байгаль орчны яамд хоорондын хамтын ажиллагааны Протоколд гарын үсэг зурав.
2003 оны 5 сарын 26-28-нд	УИХ-ын дэд дарга Ж.Бямбадорж тэргүүтэй УИХ-ын төлөөлөгчид Болгарт албан ёсны айлчлал хийв.
2003 оны 6 сарын 16-21-нд	Болгарын Эдийн засгийн орлогч сайд, худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн талаар хамтран ажиллах ЗГХК-ын Болгарын хэсгийн дарга Н.Янков Монголд айлчлав.
2003 оны 7 сард	ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Р.Алтангэрэл Болгарт айлчилж улс төрийн зөвлөлдөх уулзалт хийв.
2003 оны 10 сард	Болгарын Төрийн Засаг захиргааны сайд Д.Калчев Монголд айлчлав.
2004 он	Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Дондог даргатай Монгол, Болгарын парламентын бүлэг байгуулагдав.
2004 оны 12 сарын 3-8-нд	Гадаад хэргийн сайд Ц.Мөнх-Оргил Болгарт айлчлав. Айлчлалын үеэр Ц.Мөнх-Оргил Софид болсон Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Гадаад хэргийн сайд нарын уулзалтад зочноор оролцсон ба Монгол Улс ЕАБХАБ-д түнш орны статустай болов.

Монгол, Польшийн харилцаа

1950 оны 4 сарын 14-нд	Хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоож 1959 онд Варшавт, 1960 онд Улаанбаатарт ЭСЯ-аа тус тус нээсэн.
1991, 1994, 1996, 1998, 2003 онд	Монгол Улсын Их Хурлын төлөөлөгчид Польшд айлчлав.
1991 он	Польшийн Сенатын дэд маршал З.Куратовска Монголд айлчлав.
1993, 1995 он	Польшийн Гадаад явдлын яамны төлөөлөгчид Монголд айлчлав.
1995 он	Польшийн Сенатын маршал Монголд айлчлав.
1995 он	Монгол Улсын Гадаад харилцааны дэд сайд Польшд айлчлав.
1995 оны 3 сард	Копенгаген хотноо болсон дэлхийн дээд хэмжээний уулзалтын үеэр Монгол Улсын Ерөнхий сайд Польшийн Ерөнхийлөгчтэй уулзаж ярилцсан.
1995 оны 6 сард	1954-1994 онд Монгол, Польшийн хооронд байгуулсан гэрээ, хэлэлцээрүүдийг цэгцлэх асуудлаар Улаанбаатар хотноо мэргэжилтний уулзалт болов.
1995 оны 11 сар	“Хөрөнгө оруулалтыг харилцан дэмжих, хамгаалах тухай” хэлэлцээрт гарын үсэг зурав.
1996 он	Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Б.Чимид Польшд айлчлав.
1997 он	УИХ-ын дарга Р.Гончигдорж Польшд айлчлав.
1997 он	Польшийн Гаалийн Ерөнхий газрын дарга Монголд айлчлав.
1997 оны 4 сар	“Орлогын ба хөрөнгийн татварыг давхардуулан олгохгүй байх тухай” хэлэлцээрт гарын үсэг зурав.
1997 оны 5 сар	“Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай” хэлэлцээр байгуулав.
1998 он	Польшийн Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга хатагтай Д.Хюбнер Монголд айлчлав.
1998 он	Төрийн хянан шалгах хорооны дарга Л.Жавзмаа, МАХН-ын ЕНБД Л.Энэбиш, Нийслэлийн засаг даргын орлогч Я.Мөнхжаргал, ХЗЯ-ны ТНБД Д.Сугар нарын төлөөлөгчид Польшд айлчлав.
1998 оны 10 сар	Хоёр орны иргэдэд эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх шинэ Гэрээнд гарын үсэг зурав.
1999 он	Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди Польшд айлчлав.

1999 он	Польшийн Гадаад хэргийн яамны Ерөнхий захирал М.Радлицки, Польш, Монголын парламентын бүлгийн дарга М.С.Янковски тэргүүтэй парламентын төлөөлөгчид Монголд айлчлав.
2000 он	Нью-Йоркт болсон Мянганы дээд хэмжээний уулзалтын үеэр Ерөнхийлөгч Н.Багабанди, А.Квашневски нар уулзаж ярилцав.
2000 он 5 сар	Хоёр улсын Шинжлэх ухааны академиудын хооронд 2000-2002 онд хамтран ажиллах тухай протоколд гарын үсэг зурав.
2001 он	Польшийн Гадаад хэргийн яамны Консулын департаментын захирал А.Кремер тэргүүтэй төлөөлөгчид Монголд айлчлав.
2001 он	БНПУ-ын Элчин сайд Кшиштоф Дембницки Итгэмжлэх жуух бичгээ барив.
2001 он	БНПУ-ын Сеймийн Үндсэн хуулийн хариуцлагын комиссын дарга Е.Гвиж тэргүүтэй парламентын төлөөлөгчид Монголд айлчлав.
2002 он	Сеймийн Тамгын газрын дарга тэргүүтэй төлөөлөгчид Монголд айлчлав.
2002 он	Монгол Улсын Элчин сайд Т.Баасансүрэн Итгэмжлэх жуух бичгээ барив.
2003 оны 5 сар	Хоёр улсын Боловсролын яамд хоорондын 2003-2005 оны хамтын ажиллагааны Хөтөлбөрт гарын үсэг зурав.
2004 оны 3 сард	Польш, Монголын парламентын бүлгийн дарга хатагтай Э.Раджишевска тэргүүтэй Сеймийн төлөөлөгчид Монголд айлчлав.
2004 оны 8 сард	Польшийн Гадаад хэргийн сайд В.Чимошевич тэргүүтэй төлөөлөгчид Монголд айлчлав.

Монгол, Унгарын харилцаа

1950 оны 4 сарын 28-нд	Хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтсон.
1991 он	УБХ-ын дарга Р.Гончигдорж Унгарт айлчлав.
1991 он	Унгар Улсын Их Хурлын орлогч дарга М.Сюреш Монголд айлчлав.
1991, 2002 онд	“Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах төлөвлөгөө”-нд гарын үсэг зурсан.

- 1991-1995, 1996-2000, 2001-2005 онд хоёр орны ШУА-ийн хооронд хамтран ажиллах төлөвлөгөө байгуулан ажиллаж байна.
- 1993 он “Дипломат болон албан паспорт бүхий иргэд харилцан визгүй зорчих тухай” Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулсан.
- 1994 он БНУУ-ын Ерөнхийлөгч Генц Арпад Монголд айлчлав.
- 1994 он Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээр байгуулав.
- 1994 он Эдийн засаг, худалдаа, ШУТ-ийн хамтын ажиллагааны комисс байгуулах, түүний үйл ажиллагааны тухай хэлэлцээр байгуулав.
- 1995 он Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат Унгарт айлчлав.
- 1995 он УИХ-ын орлогч дарга Ж.Гомбожав Унгарт айлчлав.
- 1995, 1998 онд Монгол, Унгарын эдийн засгийн хамтын ажиллагааны ЗГХК-ийн хуралдаан Будапешт хотод, 1997 онд Улаанбаатарт болсон.
- 1995 он Гаалийн талаар хамтран ажиллах, харилцан туслах тухай хэлэлцээр байгуулав.
- 1997 он БНУУ-ын Их Хурлын орлогч дарга Катоди Мариа тэргүүтэй төлөөлөгчид Монголд айлчлав.
- 1998 он Монгол Улсын Ерөнхий сайд М.Энхсайхан Унгарт айлчлав.
- 1998 он Хоёр улсын хооронд “Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны” гэрээ байгуулав.
- 1999 он УИХ-ын дарга Р.Гончигдорж Унгарт айлчлав.
- 2001 он БНУУ-ын Их Хурлын орлогч дарга Сили Каталин Монголд айлчлав.
- 2003 он УИХ-ын орлогч дарга Ж.Бямбадорж Унгарт айлчлав.
- 2003 он ГХЯ-ны ТНБД Р.Алтангэрэл тэргүүтэй төлөөлөгчид Унгар Улсад айлчлан ГХЯ-дын зөвлөлдөх уулзалтыг Будапешт хотод хийв.
- 2004 оны 1 сар Унгар Улсын Их Хурлын дарга Сили Каталины ивээл дор хоёр орны “Бизнес, эдийн засгийн форум” Будапешт хотод болов.

Монгол, Чехийн харилцаа

1950 оны 4 сарын 25-нд	Хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтсон. (Чех Улстай 1993 оны 1 сарын 1-нд дипломат харилцаа тогтоосон)
1993, 1994 он	Чехийн ГХЯ-ны 4 дүгээр газрын захирал И.Соукуп, Гадаад хэргийн дэд сайд Х.Бамбасова нар Монголд тус тус айлчлав.
1994 он	Засгийн газрын шадар сайд Л.Энэбиш Чех Улсад айлчлав.
1995 он	Монголын Хүн амын бодлого, хөдөлмөрийн дэд сайд, Гадаад харилцааны дэд сайд, Худалдаа үйлдвэрийн сайд тус тус Чех Улсад зочлов.
1995 он	Чехийн Үйлдвэр, худалдааны Яам, ГХЯ-ны П.Вацек тэргүүтэй төлөөлөгчид, ҮХЯ, СЯ, Үндэсний Банкны хамтарсан төлөөлөгчид Монголд ажлын айлчлал хийв.
1995 он	Хоёр орны хооронд Худалдааны Хэлэлцээр байгуулав.
1996 он	С.Зориг тэргүүтэй УИХ-ын төлөөлөгчид Чех Улсад айлчлав.
1997 он	Хоёр улсын Ерөнхий сайд М.Энхсайхан, В.Клаус нар Швейцарийн Давос хотноо болсон Дэлхийн эдийн засгийн Чуулга уулзалтын үеэр уулзаж Монгол, Чехийн харилцаа, хамтын ажиллагааг идэвхжүүлэх асуудлыг хөндөж ярилцав.
1997 он	Чехийн ГХЯ-ны Соёлын газрын захирал З.Лычка тэргүүтэй төлөөлөгчид, Чехийн ажил хэрэгч хүмүүсийн төлөөлөгчид, Соёлын яамны төлөөлөгчид Монголд айлчлав.
1997 он	Хоёр орны хооронд Давхар татвар ноогдуулахгүй тухай Хэлэлцээр байгуулав.
1998 он	Чехийн Парламентын төлөөлөгчдийн Танхимын Тамгын газрын дарга Д.Кынштетр тэргүүтэй төлөөлөгчид Монголд айлчлав.
1998 он	Хоёр орны хооронд Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Хэлэлцээр байгуулав.
1998 он	Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай засгийн газар хоорондын Хэлэлцээр байгуулав.
1999 он	Чехийн Гадаад хэргийн сайд Ян Каван Монголд айлчлав.

1999 он	Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди Чехэд төрийн айлчлал хийв.
1999 он	Хоёр орны Гадаад харилцааны яамдын хамтын ажиллагааны тухай протоколд гарын үсэг зурав.
1999 он	Аж ахуйн нэгж, байгууллагуудад иргэд харилцан илгээж ажиллуулах нөхцлийн тухай хоёр улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээрт Прага хотноо гарын үсэг зурав.
2000 он	Чехийн Сенатын Байнгын хорооны дарга П.Смутны тэргүүтэй төлөөлөгчид Монголд айлчлав.
2002 оны 4 сард	Гадаад хэргийн дэд сайд С.Батболд тэргүүтэй төлөөлөгчид Прага хотноо улс төрийн зөвлөлдөх уулзалт хийв.
2003 оны 10 сард	Монгол, Чехийн Засгийн газар хоорондын комиссын анхдугаар хуралдаан Улаанбаатар хотноо болов.

Монгол, Румыний харилцаа

1950 оны 4 сарын 29-нд	Хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтсон.
1991 он	Румыний ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга тэргүүтэй төлөөлөгчид Монголд айлчлав.
1995 он	Монголын Гадаад харилцааны дэд сайд Ч.Баатар Румынд айлчлав.
1995 он	Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Засгийн газар хоорондын Хэлэлцээр, ГЯЯ-дын хамтын ажиллагааны протоколыг байгуулсан.
1990-1997 он	Хоёр улсын Үндсэн хуулийн шүүх, цэцийн төлөөлөгчид, Дээд шүүхийн төлөөлөгчид харилцан айлчилсан.
2000 он	Румын Улсын Элчин сайд Иоан Донка Итгэмжлэх жуух бичгээ барив.
2001, 2002 он	Ерөнхий сайд Н.Энхбаяр НҮБ-ын Ерөнхий Ассамблейн Чуулганы үеэр Румын Улсын Ерөнхийлөгч И.Илиескутэй уулзаж хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааны талаар санал солилцов.

Монгол, Словакийн харилцаа

1993 оны 1 сарын 1-нд	Монгол Улс Бүгд Найрамдах Словак Улсыг тусгаар тогтносон өдрөөс нь хүлээн зөвшөөрч, хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтов. Урьд
-----------------------	---

1994 он	Чехословак Улсын хүрээнд 1950 оны 4 сарын 25-аас хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа эхэлсэн. Хоёр орны хооронд Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай, Давхар татвар ногдуулахгүй байх тухай хэлэлцээрийн төслүүдийг Монголын тал гардуулсан.
1995 он	Худалдааны хэлэлцээр, Эрүүл мэндийн салбарт хамтран ажиллах хэлэлцээр (1994)-ийн төслийг Словакийн тал гардуулсан.
1995 он	Гадаад харилцааны дэд сайд Ч.Баатар Словакт айлчлав.
1995 он	Словакийн Сангийн Яам, Худалдаа, үйлдвэрийн яамны төлөөлөгчид Монголд айлчлав.
1997 он	Словакийн анхны Элчин сайд В.Климо Итгэмжлэх жуух бичгээ барив.
1997 он	Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих хэлэлцээрийн төслийг Словакийн тал гардуулав.
2000 он	Монгол, Словак, Чехийн гурван талын санхүүгийн байгууллагуудын шинжээчдийн уулзалт Улаанбаатар хотод болов.
2003 он	Улаанбаатар хотноо зохиогдсон АШСТО-ын олон улсын V бага хуралд Словакийн Элчин сайд П.Паулен оролцов.

БНПУ-ААС МОНГОЛ УЛСАД СУУГАА ОНЦ БӨГӨӨД БҮРЭН ЭРХТ ЭЛЧИН САЙД КШИШТОФ ДЭМБНИЦКИЙН ХЭЛСЭН ҮГ

Би профессор Л.Оюунгэрэл гуайн илтгэлийг их анхааралтай сонслоо. Их баярлалаа. Монгол болон Төв, Зүүн Европын харилцаа, Монгол, Польшийн харилцааг өндрөөр үнэллээ. Энд нэг л цохон тэмдэглэмээр асуудал байна. Энэ бол бидний тэмдэглэсэнчилэн 2,7 сая.долларын өрийн асуудал бөгөөд бид тодорхой байр сууринд хүрч чадаагүй, одоог хүртэл хэлэлцсээр байгаа юм. 2004 онд Польшийн ГХЯ-ны сайд Монголд айлчлах үеэрээ “Энэ мөнгийг Польшид сурч байгаа монгол оюутнуудын сургалтын тэтгэлэгт шилжүүлбэ” гэдэг санааг дэвшүүлсэн. Бид жил болгон тэдгээр оюутнуудад зориулж 10 гаруй тэтгэмжит сургалт явуулдаг.

Одоо би та бүгдтэй миний 4 жил Монголд байсантай холбоотой зарим сэтгэгдлээ хуваалцмаар байна. Би 2001 онд Монголд ирсэн бөгөөд өнөөдрийн байдлаар бараг Монголын бүх нутгаар аялсан. Тэгэхэд би Монгол болон Польш улсуудад хэд хэдэн төстэй зүйлүүд, асуудлууд байгааг олж мэдсэн юм. Юуны өмнө 2 улс нь хоёулаа геополитикийн үүднээс түүхэн маш адил нөхцөл байдалд байдаг, манай хоёр улс урт хугацааны турш олон тооны асуудлуудтай явж ирсэн хоёр том гүрэнтэй зэрэгцэн оршдог. Бид эдгээр асуудлуудад ижил төстэй шийдвэрийг олохыг хичээж ирсэн, тодруулбал энэ нь Монголын хувьд гурав дахь хөршийн асуудал юм. Монголын улс төрийн хувьд энэ нь шинэ юм биш олон жилийн турш яригдаж байгаа асуудлууд юм. XX зууны эхэн үед сүүлчийн хаан - Богд хаан гурав дахь хөршийг хайж байсан.

Бид 1939 оноос өмнө холбоотнуудын сүлжээг зохицуулах гэж хичээснээрээ гурав дахь хөршүүдийг хайж байсан юм. Бид нарын шууд холбоотон байсан улсууд бол Их Британи, Франц хоёр юм. Гэхдээ энэ нь бол геополитикийн үзэл бодлын талаар юм гэдгийг хэлмээр байна. Монголын улс төр, эдийн засгийн системд бүтцийн өөрчлөлт хийхэд тулгарч буй хүндрэлүүд нь манай хоёр улсын хувьд их өөр байгаа юм. Үүний шалтгаан нь юу вэ? гэвэл дээр хэлсэнчилэн бид өөр түүх, газар нутаг болон хүмүүстэй, мөн мэдээж өөр түүхэн сургамжтай юм. Миний эцэг эх, өвөг эцгийн үеийг би одоог хүртэл дурсан санасаар байгаа бөгөөд би үүнийг Польш дахь хэвийн улс төр, эдийн засгийн системийн үе байсан гэж нэрлэмээр байна. 1999 оноос хойш Польшид батлагдсан хууль тогтоомжийн нилээд хэсэг нь 1920-д оны Польшийн хууль

тогтоомжийн эргэн тойронд бүрэлдсэн юм. Жишээлбэл: Польшийн компаниудын хоорондын эдийн засгийн харилцааг зохицуулдаг гол хууль нь 20-иод оны үеийн хууль тогтоомжоос эхтэй. Мэдээж өөрчлөлтүүдийг хийсэн, учир нь цаг хугацаа үргэлж нэг янзаар байдаггүй тул эдийн засаг ч, улс төр ч, харилцаа ч өөрчлөгдөж байна.

Гэхдээ шинэ санаануудын үндэс суурь нь тэдгээр үеээс гарч ирж байгаа бөгөөд тэдгээр бүх зүйлс нь Монголд байхгүй байна. Миний харж байгаагаар Монголын улс төр, эдийн засгийн бүтцийг шинэчлэх, өөрчлөхтэй холбоотой хүндрэлүүд нь Монголын түүхэнд ардчилсан нийгмийн үндэс болох тийм үндсэн ойлголт, санаа байхгүй гэдэг баримттай тулгарч байна.

Үүнийг би хэлмээр байна; хүн болгон, хувь хүн болгон өөрийн улсын улс төрийн системд нөлөөлөх эрхтэй гэсэн ойлголт байхгүй байна.

2-т, Салан тусгаарлах хүчнүүдээс илүү Европын анхдагч дүрмүүд, бие даасан шүүхийн эрх мэдэл болон бодит байдал дээр чөлөөт эдийн засгийн талаар ойлголт байхгүй байна. Энэ бүх зүйлс нь улс орны хувьд маш хэцүү нөхцөл байдлыг бий болгосон байна. Өнгөрсөн 4 жилийн хугацаанд Монголын агуу үсрэлт, дэвшлийг харж байхад та бүхэн яаж миний эх орон Польштой харьцуулахад энэ хүнд нөхцөлд та нарын хийсэн дэвшлийг харахад үнэхээр сэтгэл хөдөлж байна, үүнийг би чин сэтгэлээсээ хэлж байна. Яагаад гэвэл хэрвээ бүх юм өөр байсан бол ямар нэгэн юм хэлэх шаардлагагүй юм. Би үргэлж өөрийн туслахууд болон барууны мэргэжил нэгт нөхөддөө “Илүү тэвчээртэй бай, Монгол нь өөрийн хөгжлийн замтай, яагаад гэвэл Монгол нь өөрийн түүх, сорилтуудтай” гэж хэлдэг. Монголчууд нь Польш, Төв болон Зүүн Европын орнуудын 40 жилийнхтэй харьцуулбал 80 жил коммунист системтэй байсан, энэ нь бараг 4 үе юм, тийм болохоор би буцаж очоод энэ нь өөрчлөхөд ямар хэцүү юм бэ, бодож сэтгэх хуучин барилаасаа татгалзах, орчин үеийн ертөнц рүү шилжих нь ямар хэцүү юм бэ гэдгийг олж үзнэ. Орчин үеийн ертөнц рүү шилжих гэдэг нь би зөвхөн тэр хүний эрхийн талаархи онолын асуудлууд, чөлөөт хэвлэл болон эдгээр бусад зүйлсийг хэлээгүй, гэхдээ маш бодит зүйлс юм. Би санаж байна, орон сууцандаа утас тавиулах гэж 13 жил хүлээх хэрэгтэй болж байсан. Энэ бол энд байгаа ихэнх хүмүүсийн хувьд гайхмаар зүйл юм. Харин бидний хувьд бол тийм ч сонин юм биш. Бид энд суун үүнийг их хэвийн гэж ойлгож байна. Энэ бол ерөнхийдөө та бүгдэд хэлэх гэсэн зүйл байгаа юм.

Миний хувьд Монгол нь өөрийн маш амжилттай 4 ерөнхий сонголттой; маш сайн эдийн засгийн өсөлтийг амлаж буй; ээлжит

ерөнхийлөгчийн сонгууль болно. Үндсэндээ би нилээн гайгүй амьдралын түвшин гэдгийг хэлэх ёстой. Би хөдөө орон нутгаар аялж байхдаа Азийн бусад оронд харж байсан шиг Монголд ядуурлыг ихэсгэж буй зүйл юу ч олж хараагүй. Монгол бол амжилттай орны хамгийн сайхан жишээ юм. Би бол “амжилттай орон” гэж нэрлэмээр байна. Магадгүй үйл явц сайжирч магадгүй, магадгүй хурдасч болох юм гэхдээ ерөнхийдөө би энэ бүгдийг маш амжилттай гэж нэрлэмээр байна.

Миний бодлоор Монгол орон бол хамтран ажиллахад Польшийн хувьд маш сонирхолтой орон юм. Энэ хамтын ажиллагаа сүүлийн жилүүдэд нилээд хурдацтай өсөн нэмэгдэж байна. Профессор Л.Оюунгэрэлийн тэмдэглэсэнчлэн манай хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагаа, худалдаа 2000 онд 5 сая ам.доллар байсан бол 2003 онд 8 сая ам.доллар болсон. 2004 онд энэ нь бага зэрэг өссөн, гэхдээ их хэмжээгээр өсөөгүй. Би хувьдаа бол Монгол орныг Польшийн нухацтай хөрөнгө оруулалт хийхэд сонирхолтой орон, сонирхолтой түнш гэдэгт итгэж байна. Их хэмжээний хөрөнгө оруулалт бол мэдээж нилээд цаг хугацааг шаардана. Тэгээд үүнд сайн бэлтгэл, сайн үндэс суурь шаардлагатай. Миний эхэнд тэмдэглэсэн асуудал өрийн асуудал нь, бодит байдал дээр жижиг асуудал боловч харамсалтай нь Польшоос Монголд оруулах илүү их хэмжээний хөрөнгө оруулалтанд чиглэсэн үйл явцад саад учруулж байна, яагаад гэвэл цэвэр хуулийн шалтгаануудын улмаас. Монголд хөрөнгө оруулах сонирхолтой байгаа Польшийн компани жам ёсоор хөрөнгө оруулалтандаа даатгалыг эрж хайх болно. Энэ даатгал нь өрийн асуудлаа шийдвэрлээгүй улсад хангагдахгүй юм. Тэгэхээр энэ 2,7 сая доллар нь нэг талаар Монголын Польшид төлөх ёстой өрийн бага хэсэг ч энэ Монгол, Польшийн хоёр талт худалдааны тэнцвэргүй байдлыг шийдэх их хэмжээний хөрөнгө оруулалтын боломжуудыг олж болох юм. Яагаад гэвэл энэ 8 сая.доллар нь бараг бүхэлдээ Польшийн импорт байгаа юм.

Энэ бол бидний аль болох түргэн шийдвэрлэх ёстой зүйл бөгөөд үүнийг манай ГЯЯ-ны сайд 2004 онд айлчлахдаа санал болгосончлон шийдэх боломжтой гэдэгт найдаж байна.

Анхаарал тавьсанд маш их баярлалаа.

БНБУ-ААС МОНГОЛ УЛСАД СУУГАА ОНЦ БӨГӨӨД БҮРЭН ЭРХТ ЭЛЧИН САЙД НИКОЛАЙ МАРИНЫ ХЭЛСЭН ҮГ

Монгол болон Зүүн Европын орнуудын хооронд дипломат харилцаа тогтоосны 55 жилийн ойд зориулсан дугуй ширээний уулзалтанд үг хэлэх боломж олгосонд талархлаа илэрхийлье. Би өөрийн мэргэжил нэгт нөхөр К.Дэмбнишкийн адилаар профессор Оюунгэрэлийн ярьсан зүйл маш өргөн хүрээг хамарсан гэдгийг тэмдэглээд хэдэн зүйл нэмж хэлэх гэсэн юм. Би өөрийн мэргэжил нэгт нөхөр, элчин сайд К.Дэмбнишкийн үзэл бодлыг бүрэн дүүрэн хуваалцаж, бас өөрийн санал дүгнэлтийг хуваалцмаар байна. Миний бодлоор Монгол нь баруун Европын орнуудтай харилцах их өргөн боломжтой юм. Монгол өнгөрсөн зуунд иргэншлийн хувьд шинэ түвшинд гарч, европчуудтай их энгийн харилцах боломжтой нийгмийг бий болгосон юм. Энд ирж буй бүх европчууд монголчуудтай Азийн бусад орны хүмүүстэй харьцахаас илүү амар байдаг хэмээн сэтгэгдлээ хуваалцдаг юм. Үүнийг би цааш нь хөгжүүлэх боломжтой давуу тал гэж үзэж байна.

Өөр нэг тэмдэглэх зүйл бол манай улсуудын хагас зуун жилийн хугацаанд хөгжүүлж ирсэн харилцаа, хамтын ажиллагаа нь үнэн хэрэгтээ маш сайн бааз суурь бөгөөд энэ бааз суурийг зүй ёсоор үнэлэх цаг болсон бөгөөд энэ суурь дээр тулгуурлан цааш ахих боломж, эх үүсвэр бий болжээ.

Манай улс болон Монгол Улс зах зээлийн эдийн засаг, ардчилалд шилижин орсонтой холбоотойгоор тогтолцоогоо шинэчлэхэд илүү анхаарч байлаа. Манай орнуудын харилцаа нэг хэсэг зогсонги байсан ба харин өнөөдөр манай хоёр орны хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэх илүү боломжтой болсон юм. Энэ тал дээр бидэнд түшиж тулах нөхцлүүд бий. Юу вэ гэвэл байгалаас заяасан бие биендээ сайнаар хандах шалтгаан байсан юм. Энэ нь бидний 55 жилийн хамтын ажиллагааны үр дүн юм. Энэ 55 жилгүйгээр бидний харилцааг Монгол, Баруун Европын жижиг улсуудын харилцаанаас илүүтэйгээр хөгжүүлж чадахгүй байсан гэж бодож байна. Хэрэв Монгол-Болгарын харилцааг Монгол, Баруун Европын ямар нэгэн жижиг улсын харилцаатай харьцуулах юм бол үр дүн нь манай хоёр орны хоорондын харилцаанд ашигтай гарах болов уу. Нэг үгээр хэлэхэд бидэнд маш сайн уламжлал, үүний үр дүн болох сайн харилцаа байна. Тийм уламжлал байгаагүйсэн бол жишээлбэл бидний хооронд 1995 оны найрсаг харилцаа, хамтын ажиллагааны талаархи гэрээ байхгүй байх байсан гэж бодож байна. Нэмж хэлэхэд энд байгаа хүмүүсийн зарим нэг нь мэдэхгүй байж магадгүй, гэхдээ би манай улсын зүгээс Азийн улсуудтай байгуулсан энэ төрлийн цорын ганц гэрээ гэдгийг сайн мэдэж байна. Үүнээс гадна эдийн засгийн хамтын ажиллагааны тал

дээр бид хоцрогдож яваа, их ажиллах хэрэгтэй, энэ бол удаан үргэлжлэх үйл явц бөгөөд бид мөн Польштой адил бие биендээ өртэй, би мэргэжил нэгт нөхөр К.Дэмбнишкийн нэгэн адил асуудлыг шийдэх хэрэгтэй гэдэг байр суурин дээр байна. Энэ бол тийм их хэцүү, том асуудал биш юм. Энэ асуудлыг хэдий хэр хурдан шийднэ тэр тусмаа л сайн. Би өнөөгийн олон улсын нөхцөл байдалд Монгол, Болгар шиг жижиг улсуудын хооронд харилцан ашигтай харилцааг хөгжүүлэх боломжтой гэдэгт та бүгдийн анхаарлыг хандуулахыг хүсч байна. Өнгөрсөн жилийн сүүлчээр Монгол нь Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагад элсэн орсон явдлыг дурьдаж болох юм. Өнгөрсөн жил Монгол Улс нь Европын гэж хэлж болохуйц энэ байгууллагад элсэн орох саналаа гаргахад асуудлыг түргэн шийдвэрлэх тал дээр энэ байгууллагын төлөөлөгчийн хувьд Болгар улс их ашигтай үүрэг гүйцэтгэсэн юм. Энэ байгууллагад АНУ, Канад болон бусад орнууд элсэн орсон учраас зөвхөн Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага гэж хэлж болохгүй юм. Монголын дээрх санаачлага нь гадаад бодлого дахь Европын чиглэлийн нэгэн баримт юм. Европын бусад орнуудтай харилцах, түүнийгээ хөгжүүлэх сайхан боломжийг олгож буй улс төрийн энэхүү үйлдлийн ач холбогдолыг үнэлж баршгүй юм.

Манай хоёр талын шууд харилцааны хувьд 90-ээд оноос хойшхи хөгжлийн үндсэн зүйлсүүд нь дээд хэмжээнд төрийн айлчлал хийх, Ерөнхийлөгчид харилцан айлчлах явдал байлаа. 1995 онд манай улсын Ерөнхийлөгч Монголд айлчилж Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ байгуулсан билээ. 2000 онд Монголын Ерөнхийлөгч Болгарт, 2002 оны эцсээр манай АИХ-ын дарга тэргүүтэй төлөөлөгчид Монголд айлчилсан. Өнгөрсөн жил 1990-ээд оноос хойш анх удаа сайдуудын хэмжээнд харилцан айлчлал хийгдлээ. Өнгөрсөн хугацаанд хоёр орны харилцааны эрх зүйн асуудлыг шинэчилсэн, энэ үйл явц одоо ч үргэлжилж байна. Мөн бид 4 сарын 25-нд Европын холбоонд нэгдэн орох талаар гэрээнд гарын үсэг зурна, үүнтэй холбоотойгоор хоёр талын гэрээ, зөвшилцлүүд ялангуяа эдийн засгийн салбарынхыг дахин хянах учир цаашид ч ажиллах шаардлагатай юм. Төрөл бүрийн салбарт хамтын ажиллагаа идэвхитэй хөгжиж байгаа бөгөөд энэ тал дээр манай мэдээллийн хэрэгслүүд, радио, телевиз, мэдээллийн агентлагуудын хооронд байгуулсан гэрээний хүрээнд хөгжиж буй харилцааг би их үнэлж байгаа. Батлан хамгаалахын салбарт ч хамтын ажиллагаа хөгжиж байгаа бөгөөд бид батлан хамгаалахын атташег томилчихсон, энэ салбарт хамтран ажиллах талаар хэлэлцээр байгуулахаар зэхэж байна. Мөн олон зүйлүүд хамтран ажиллахаар төлөвлөсөн байгаа, олон зүйл ярьж болох юм.

Анхаарал тавьсанд баярлалаа.

БНУУ-ААС МОНГОЛ УЛСАД СУУГАА ОНЦ БӨГӨӨД БҮРЭН ЭРХТ ЭЛЧИН САЙД ИЛЛЭШ МИХАЙН ХЭЛСЭН ҮГ

Унгар улс түүнчлэн Төв ба Зүүн Европын бусад хэдэн улс болон Монгол Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 55 жилийн ойг тохиолдуулан өнөөдрийн энэхүү дугуй ширээний ярилцлагыг зохион байгуулж байгаад, “Олон улс судлал” улирал тутмын сэтгүүл энэ үйл явдлыг тохиолдуулан тусгай дугаар гаргаж байгаад юуны өмнө Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Олон Улс Судлалын Хүрээлэн болон Монгол Улсын Гадаад Хэргийн Яаманд талархаж байна.

Унгар-Монголын харилцааны талаар ярихын өмнө энэхүү чуулганд үг хэлэх завшааныг ашиглан 10 сая хүн амтай Бүгд Найрамдах Унгар Улсын байдлын талаар хэдэн үг хэлэхийг хүсэж байна.

1989 онд тайван замаар эхэлсэн тогтолцооны өөрчлөлтийн хүнд ачаа, эдийн засгийн уналтын зовлон бэрхшээлтэй тулалдангаа, тогтолцооны өөрчлөлтийн өмнөх үеийн эдийн засгийн үзүүлэлтүүддээ харьцангуй хурдан хүрч чадсанаар улс орноо хурдасч буй эдийн засгийн хөгжлийн зам руу дахин аваачсан билээ. НАТО, нэн ялангуяа ЕХ-ны гишүүнчлэлд нэгдэн орох нөхцлийг бүрдүүлэх нь ул суурьтай, асар их бэлтгэл ажлыг шаардаж байв. 90-ээд оны эхээр Унгар-Монголын харилцааг хөгжүүлэхэд Унгарын зүгээс бид ч зохих ёсны анхаарал тавьж чадаагүй билээ. 1990 оноос өнөөг хүртэл манай парламентийн бүхий л циклүүдэд эвслийн засгийн газар ажиллаж байсан бөгөөд энэ нь манай парламентийн бүхий л намууд эвсэлдэн удирдах олон жилийн туршлагатай гэсэн үг юм. Элбэгдоржийн засгийн газартай нэгэн хугацаанд байгуулагдсан Дьюрчанийн засгийн газар - засгийн газрын тэргүүнийг мөн оролцуулан - 18 гишүүнтэй. Засгийн газрын 17 гишүүний хоёр нь эмэгтэй сайд. Ерөнхийлөгч болон нэг танхимтай парламентийн эрх зүйн байдал нь Монголынхтой нэн төстэй. Унгарт ч мөн л ерөнхийлөгчийн сонгуулийн өмнөх үе болж байгаа бөгөөд зургадугаар сарын 5 эсвэл 6-нд парламентийн намуудын нэр дэвшигч нарын аль нэгийг Парламент сонгоно. Бид түүхэндээ анх удаагаа эмэгтэй ерөнхийлөгчтэй болно хэмээн төсөөлөхөд ер нь боломжтой байгаа агаад тэрбээр 2003 онд парламентийн дэд дарга байхдаа манай төлөөлөгчдийг тэргүүлэн Монгол Улсад айлчилж байсан, одоогийн парламенгийн дарга хатагтай Сили Каталин юм. Улс орны засаг захиргааг өөрчлөн зохион байгуулах, одоогийн мужийн тогтолцооноос ЕХ-ны шаардлагыг хангаж

чадахуйц хөгжлийн бүсүүд болгон өөрчлөх нь хүчтэй эсэргүүцлийн улмаас нэн бэрхшээлтэй байсан гэдгийг бидний хоорондох ижил төстэй олон зүйл дээр нэмж хэлэхийг хүсэж байна. Хэрвээ энэ чиглэлээр Монгол Улс биднээс өмнө хөдөлж чадвал ашиглаж болохуйц туршлагыг хожим бидэнд ч мөн өгч болох юм.

Эдүгээ Унгар улсын эдийн засгийн өсөлт тогтмол 4-5% өөрөөр хэлбэл ЕХ-ны дундажаас хоёр дахин их байна. Эл үзүүлэлт болон ЕХ-ны хэрэгжүүлж буй эдийн засгийн талаар гүйцэн очих хөтөлбөр нь тодорхой хугацааны дотор ЕХ-ны хөгжлийн дундаж үзүүлэлтүүд болон амьжиргааны түвшинд хүрч очих баталгаа болж байна. Унгар улс 2007 оны нэгдүгээр сарын 1-ээс Шенгений гэрээнд нэгдэн орох бэлтгэлээ хийж байгаа бөгөөд 2010 оны нэгдүгээр сараас еврогийн бүсийн хэсэг болох төлөвтэй.

Манай улс 1950 оны дөрөвдүгээр сарын 28-нд Монгол Улстай дипломат харилцаа тогтоосон бөгөөд удалгүй хоёр улсын нийслэлд харилцан элчин сайдын ямаа байгуулсан билээ. Хоёр орны хоорондох уламжлалт найрсаг харилцаа, хамтын ажиллагаа, харилцан итгэлцэлд тулгуурласан манай улс төрийн харилцаанд саад бэрхшээл байхгүй. Нийгмийн тогтолцоог тайван замаар өөрчлөх үйл явц манай хоёр оронд бараг нэгэн зэрэг өрнөсөн. Харилцаа, хамтын ажиллагаагаа улс төр, эдийн засгийн шинэ нөхцөлд зохицуулан, хөгжүүлэхэд дээд хэмжээний харилцан айлчлалууд үлэмж ач холбогдолтой бөгөөд 1994 онд Ерөнхийлөгч Гэнц Арпад Монгол Улсад, 1995 онд Ерөнхийлөгч П.Очирбат, 1998 онд Ерөнхий сайд М.Энхсайхан Унгар улсад айлчлав. Манай хоёр орны парламентын өндөр хэмжээний төлөөлөгчдийн уулзалтууд ч тогтмолжлоо. Өнгөрсөн 15 жилийн дотор манай хоёр орны Үндсэн хуулийн Цэцийн дарга нар, Ерөнхий Прокурорууд, Дээд Шүүхийн дарга нар болон Монгол, Унгарын засгийн газрын олон гишүүн харилцан айлчилсан бөгөөд эдгээр айлчлалын үеэр шинэ гэрээ хэлэлцээрүүдэд гарын үсэг зурснаар хуучныг нь халсан байна. Эдгээрийн дотроос хоёр орны парламент 1998 онд соёрхон баталсан Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны гэрээг онцлон дурьдаж болно. Эдүгээ манай хоёр орон, засгийн газар, яамд, ерөнхий газрууд түүнчлэн шинжлэх ухаан, соёлын төрөл бүрийн байгууллагууд болон бусад байгууллагуудын хооронд 40 гаруй гэрээ, хэлэлцээр, хамтын ажиллагааны төлөвлөгөө хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Гадаад яамд хоорондын зөвлөлдөх уулзалтууд тогтмолжсон.

Манай хоёр орны хоорондох эдийн засгийн хамтын ажиллагаа олон жилийн туршид зогсонги байсны дараагаар 2003 оноос хурдан өсч буйг бид харж байна. 2002 онд 1,6 сая.америк доллар байсан бараа гүйлгээ 2003 онд 3,8 сая, 2004 онд бүр 7,2 сая.долларыг давж гарав. Энэ нь хоёр орны аль алинд нь нөгөөдөө түнш хайх, хамтарсан үйлдвэр эхлүүлэх талаар бизнесийн хүрээнийхний сонирхол өсч буйг илтгэнэ.

Социализмын он жилүүдэд Унгарын тусламжаар Сонгиний Биокомбинат, Дарханы Мах комбинат, Улаанбаатарын Оёдлын үйлдвэр зэрэг томоохон үйлдвэрүүд байгуулагдаж, геологи, усны аж ахуйн мэргэжилтнүүдийн томоохон бүлэглэлүүд төсөл болон хамтарсан экспедицийн шугамаар олон жилээр энд ажиллаж байлаа. 90-ээд оны хоёрдугаар хагаст бизнесийн шугамаар Улаанбаатар хотноо шар айрагны 4 жижиг үйлдвэр унгар төхөөрөмж, технологиор байгуулагдав. Саяхан унгарын нэгэн үйлдвэрийн зөвхөн Рэтро нэртэй бүтээгдэхүүнийг борлуулдаг РЭТРО дэлгүүр нээгдлээ. Унгарт ажлын гэрээгээр одоо 660 оёдолчин ажиллаж, Jeantext Company 170 монгол ажилчинтай.

Унгар улс 2000 оноос Монгол Улсыг түнш орнуудынхаа жагсаалтад дахин оруулснаар олон улсын хөгжлийн тусламжийн төслүүдийн нэг хэсгийг нь энд хэрэгжүүлэхээр бэлтгэж байна. 2005 оны төслүүдийг боловсруулах ажил хийгдэж, ойрын өдрүүдэд батлагдах төлөвтэй бөгөөд хэрэгжилт нь энэ зунаас буюу оны хоёрдугаар хагасаас эхлэнэ.

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандийн Унгар улсад хийх айлчлал нь дипломат харилцаа тогтоосны 55 жилийн ойн өдрүүдэд болох гэж байгаад бид ихээхэн баяртай бөгөөд энэ айлчлал нь манай хоёр орны харилцааг хөгжүүлэхэд нэгэн чухал өртөө болно гэдэгт итгэл төгс байна.

Энэ гуравдугаар сард Унгарын Гамшгаас хамгаалах ерөнхий газрын төлөөлөгчид Улаанбаатарт айлчилсан. Зургадугаар сард Унгарын хууль зүйн сайд, долдугаар сард Будапешт хотын дарга Монгол Улсад айлчилна. Энэ онд Унгарын Цагаачлал, иргэний харъяатын газрын урилгаар Монголын талын түнш байгууллагын төлөөлөгчид Будапештэд айлчилна. Гадаад яамд хоорондын зөвлөлдөх уулзалт мөн энэ онд Улаанбаатар хотноо болно.

Бид ирэх долоо хоногууд мөн дараа саруудад унгарын ардын дууны концерт, нэрт яруу найрагч Южэф Аттилагийн мэндэлсний 100 жилийн ойг тохиолдуулан яруу найргийн үдэшлэг, Улаанбаатар,

Дархан, Эрдэнэт хотноо унгар киноны долоо хоног, унгарын дүрслэх урлагийн үзэсгэлэн, Халашийн торон цоолборын үзэсгэлэн түүнчлэн фото зургийн үзэсгэлэн зэрэг нилээд хэдэн соёлын арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөөд байна. Мөн түүнчлэн 2006 онд унгар найруулагч урьж, унгарын драмын жүжгийг Улсын жүжгийн хүрээлэнд тоглуулахаар төлөвлөж байна.

“Монголын нууц товчоо” зохиол унгар хэл дээр хоёр дахь удаагаа Унгарт хэвлэгдэн гарав. Нобелийн шагналт зохиолч Кэртэс Имрэгийн “Хувь тавилангүйтэл” роман ойрын үед монгол хэл дээр хэвлэгдэн гарна.

Монгол Улсын ардчилсан байгууллагуудын тогтолцоо, зах зээлийн эдийн засаг бий болон хөгжиж, эдийн засгийн хөгжил хурдасч буйг болон олон улсын харилцааны тогтолцоонд үүрэг оролцоо нь өсөн нэмэгдэж байгаагийн жинхэнэ үр дүнг Унгар улс өндрөөр үнэлэн харж байна. Энэ нь интеграцит байгууллагууд, НАТО, ЕХ-ны хэсэг нь болсон Унгар улс болон Монгол Улсын найрсаг харилцаа бүх салбар дахь хамтын ажиллагаа нятаршгүй хөгжихийн баталгаа мөн. Энэ зорилгод хүрэхэд Унгар улс цаашдаа ч итгэж болохуйц буурь суурьтай түнш байх болно.

Анхаарал тавьсанд баярлалаа.

БНЧУ-ААС МОНГОЛ УЛСАД СУУГАА ОНЦ БӨГӨӨД БҮРЭН ЭРХТ ЭЛЧИН САЙД ЙИРЖИ НЕКВАСИЛИЙН ХЭЛСЭН ҮГ

Та бүхэнд өнөөдрийн дугуй ширээний ярилцлагад урьсан явдалд талархаж байгаагаа илэрхийлье. Монгол Улс болон тэр үеийн Чехословак улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 55 жилийн ойн баяр тохиож байгаа энэ өдрүүдэд Бүгд Найрамдах Чех Улсын талаар богино мэдээлэл хийж байгаадаа баяртай байна. БНЧУ байгуулагдсан түүх ба шинэ үеийн түүхийн чухал үйл явдлуудыг товчхон өгүүлэх нь илүү ач холбогдолтой гэж бодож байна.

1993 оны 1 сарын 1-д Бүгд Найрамдах Чех Улс байгуулагдсан. Өмнө нь одоогийн Чех улсын газар нутаг Словакийн газар нутагтай нийлсэн байсан. 1918 оны 10 сарын 28-д Бүгд Найрамдах Чехословак Улс /Чех, Словак, Закарпатын Украина/ байгуулагдсан ба тус улсын анхны ерөнхийлөгчөөр Томаш Гарригуге Масарык /1850-1937/ ажиллаж байжээ.

1938 онд ерөнхийлөгч Е.Бенеш Мюнхений гэрээний дагуу Судетыг /хилийн бүс, герман үндэстнүүд голдуу амьдардаг/ Герман улсад шилжүүлжээ. 1939 оны 3 сарын 14-нд тус улсын Словакийн хэсэг нь тусгаар тогтносон ба нэг өдрийн дараа Чех, Моравын Протекторат байгуулагджээ.

Дэлхийн 2-р дайны дараа Бүгд Найрамдах Чехословак улс нь Закарпатын Украинагүйгээр дахин байгуулагдсан байна. 1960 онд Бүгд Найрамдах Социалист Чехословак Улс нэртэй болон өөрчлөгджээ. 1968 оны 8-р сарын 21-д БНЧСУ-ын газар нутгийг Варшавын гэрээний цэргүүд эзэлсэн байна.

1989 онд Торгон хувьсгалын дараа Чех, Словакийн Холбооны Улс гэж нэрлэгдэх болсон юм. 1993 оны 1-р сарын 1-д салан тусгаарлаж шинээр Бүгд Найрамдах Чех Улс болон Бүгд Найрамдах Словак Улс байгуулагджээ.

80-аад оны сүүлчээр Торгон хувьсгалын дараа Чехословак улс дахин ардчиллын замаар хөгжих боломж нээгдсэн юм. Төлөвлөгөөт эдийн засагтай, коммунист системээс зах зээлийн эдийн засагтай, ардчилсан нийгэм байгуулах нийгэм-эдийн засгийн шилжилтийн үе эхэлсэн. 40-өөд жилийн дараа болсон парламентын чөлөөт сонгуулаар хөгжлийн чиг батлагдсан. Гадаад бодлогын хүрээнд НАТО болон Европын холбооны гишүүн орон болох зорилго тавьсан билээ.

Шилжилтийн үйл явц амар байгаагүй. 40 жилийн турш социализм байгуулах явцад хувийн өмч бүрмөсөн устсан, эдийн засгийн хөгжлийн хувьд хөгжилтэй орнуудаас ихээхэн хоцрогдсон байсан ба нэг намын тогтоолцоотой засаглал нь хүний эрх ба ардчиллыг бүрэн хаагдуулсан

байлаа. Эдийн засаг, нийгэм, гадаад харилцааны оновчтой бодлого хэрэгжүүлсний үр дүнд богино хугацаанд өмч хувьчлалын хүнд асуудал, төрийн байгууллагуудын шинэчлэл ба нийгмийн чухал асуудлуудыг богино хугацаанд амжилттай шийдвэрлэж чадсан юм.

Эхэн үеийн хүнд байдлын дараа эдийн засаг аажмаар тогтворжиж, нийт бүтээгдэхүүний өсөлт жилд дунджаар 3-4% хүрчээ. Зүүн тийш хандлагатай байсан гадаад худалдааны бүтэц өөрчлөгдөж эхэлсэн байна. Эдийн засгийн өсөлтөнд гадаадын хөрөнгө оруулалт, шинэ техник технологи нэвтрүүлсэн явдал эерэгээр нөлөөлсөн байна.

1999 оны 4-р сард Польш, Унгар улсуудын хамт НАТО-д элсэн нь БНЧУ-ын анхны түүхэн амжилт юм. Энэ нь ардчилал, зах зээлийн эдийн засгийг бүтээн байгуулах, зэвсэгт хүчний амжилттай өөрчлөлт ба Балканы хойгийн орнуудад явуулсан энхийг сахиулах үйл ажиллагаанд амжилттай оролцсон зэрэг үйл явдлуудад амжилт гаргасны үнэлгээ болсон.

БНЧУ ба Европын хамтын нийгэмлэгийн хоорондын холбооны хэлэлцээрт 1995 онд гарын үсэг зуржээ. БНЧУ 1996 онд Европын холбоонд элсэх саналаа албан ёсоор тавьжээ. Европын холбооны хууль тогтоомжтой уялдуулах ба тохиролцооны үйл явц хийгдэж эхэлсэн байна. 2004 оны 5-р сарын 1-нд Европын холбоонд гишүүнээр элссэн нь шинэ үеийн түүхийн хамгийн чухал үйл явдал болсон билээ. БНЧУ нь ардчилсан орнуудын нөхөрлөлд буцалтгүйгээр багтан орсон ба эрх чөлөөний төлөө тэмцэгчдийн олон үеийнхний мөрөөдөл биелсэн юм.

БНЧУ нь хөгжингүй аж үйлдвэртэй Европын холбооны тогтвортой гишүүн болсон байна. Гадаад худалдааны 70%-ийг Европын холбооны орнуудтай хийх худалдаа эзэлж байна. Өнгөрсөн онд дотоодын нийт бүтээгдэхүүн 4% өссөн ба нэг хүнд шилжүүлвэл 17715 ам.долларт хүрсэн ба европын 15 гэж нэрлэгддэг орнуудын эдийн засгийн чадавхын 66%-ийг эзэлж байгаа юм. Өнгөрсөн онд гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ 4 миллиард долларт хүрсэн байна.

Манай хоёр орон газар зүйн байрлалын хувьд алс оршдог ч улс төр, эдийн засаг, соёлын өргөн харилцаатай. Өнгөрсөн зууны 80-аад оны сүүлч хүртэл Монголын хувьд БНСЧСУ нь ЗХУ-ын дараа II ордог худалдааны томоохон түнш байлаа.

БНСЧСУ 1990-д оноос өмнө Монголд олон арван үйлдвэрийг барьж ашиглалтанд оруулсан түүхтэй. БНСЧСУ-ын их, дээд сургуулиудад монголын олон мянган оюутнууд суралцаж төгссөн. БНСЧСУ-д арьс шир, гутал ба техникийн чиглэлээр маш олон залуус мэргэжил эзэмшжээ.

1980 оны сүүлч, 1990 оны эхэн үед манай хоёр орны хувьд зах зээлийн эдийн засагтай тусгаар тогтносон, ардчилсан улс байгуулах шилжилтийн хүнд үе эхэлсэн билээ. Энэ үед эдийн засгийн харилцаа тодохой шалтгаануудаас хамааран зогсонги байдал орсон.

1990 оны дунд үеэс хамтын ажиллагаа дахин сэргэж эхэлсэн. 2004 онд Монгол Улс Хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд хамтран ажиллах эхний орнуудын жагсаалтанд орсон ба Улаанбаатар дахь БНЧУ-ын ЭСЯ-ыг Элчин сайд тэргүүлэн ажиллах болсон юм.

Манай хоёр орны худалдааны эргэлт сүүлийн 5 жилд 5-6 сая ам.доллар байгаа. БНЧУ-ын барилгын материалын экспорт байнга нэмэгдэж байна. (цонх, цахилгааны болон сантехникийн тоног төхөөрөмжүүд г.м)

БНЧУ-аас Хөгжлийн тусламжийн хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсад эмнэлгийн болон хүнсний үйлдвэрийн тоног төхөөрөмжүүдийг нийлүүлжээ. Тээврийн хэрэгсэл ба автобус нийлүүлж эхэлсэн байна. Монголоос БНЧУ-д хагас үнэт чулуу болон оёдлын үйлдвэрийн бүтээгдэхүүнүүд бага хэмжээгээр гаргасан байна.

БНЧУ ба Монгол Улсын хооронд байгуулагдсан гэрээ, хэлэлцээрүүд нь чанарын өндөр түвшинд хийгдсэн байдаг. Хөрөнгө оруулалтыг хамгаалах тухай, татварыг давхардуулахгүй байх тухай гэрээнүүд Чехийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлж байна.

Энэ оны 1-р сард гарын үсэг зурсан Эдийн засгийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээр нь хамтын ажиллагааг өргөжүүлэхэд хувь нэмэр болох нь дамжиггүй. Хэлэлцээрийн үр дүнд Хамтарсан комисс байгуулагдсан ба уг комиссын үйл ажиллагаа нь чехийн компаниудад бараа бүтээгдэхүүн болон тоног төхөөрөмжөө Монголын зах зээлд нийлүүлэхэд шаардлагатай мэдээлэл ба Монголын тухайн орон нутгийн хөгжлийн хэтийн төлөвийн талаарх мэдээлэл олж авахад тусална.

Чехийн аж ахуйн нэгж байгууллагууд Монгол Улсад 1991 оноос 4,6 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн байна. Европын бусад орнуудтай харьцуулахад БНЧУ нь дээгүүрт орох хөрөнгө оруулагч юм.

1990-д оноос хойш Прага хотын AlphaCon компани нь спиртын болон шар айрагны үйлдвэрийн тоног төхөөрөмж шинэчлэхэд, Eurosond компани нь барилгын чиглэлээр мөн автомат тоглоомын тоног төхөөрөмж худалдан авахад хөрөнгө оруулалт хийжээ.

БНЧУ Монгол Улсыг уламжлалт харилцаатай хамтрагч, Азийн орнуудтай харилцах гүүр хэмээн ойлгодог.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

ГХЯ-ны Хэвлэл мэдээллийн хэлтсийн дарга Б.Дорж /хурлын дарга/: Эрхэмсэг ноён элчин сайд Танд баярлалаа. Одоо Словак улсын Өргөмжит консул Энхтайван гуайг урьж байна.

Энхтайван: Энэхүү дугуй ширээний уулзалтыг зохион байгуулж надад оролцох боломж олгосон ГХЯ, ШУА-ийн ОУСХ-д талархснаа илэрхийлье. Энэ ярилцлаганд би Словак улсын тухай товчхон мэдээлэл хийе гэж бодож байна. Чех Улсын Элчин сайд ноён Неквасил Словак улсын анх үүсч бий болсон тухай сая өгүүлсэн. 1993 оны 1 сарын 1-нд Словак улс тусгаар улс болсноо зарласан. Словак улс бол Төв Европт байгаа жижигхэн улс. Нутаг дэвсгэрийн хувьд 50 мянга орчим кв.км нутагтай. 5,4 сая хүн амтай, 8 аймаг, 79 сумаас бүрдсэн улс байгаа юм. Словак улсын нутаг дэвсгэр өнгөрсөн зууны туршид янз бүрийн улсуудын бүрэлдэхүүн хэсэг болж байсан: Унгарын хаант улс, Австри-Унгарын эзэнт улс, Чехословак улс гэх мэт. Нийслэл хот нь Братислав хот 800 мянга орчим хүн амтай. Төрийн байгуулалтын хувьд Монгол Улстай ижил төстэй. Словак улсыг удирдах байгууллага нь Словак улсын парламент буюу Над нарада байдаг. Тус парламент нь Словак улсаа орчин үеийн ардчилсан улс болгон хөгжүүлэхээр ажиллаж байгаа. Чөлөөт зах зээл болон нийгмийн, экологийн чиглэлээр хөгжүүлэхийг зорьж байгаа юм. Парламент нь 4 жилийн хугацаатай, 150 гишүүнтэй, 7 намын төлөөлөл одоогоор оролцоод байгаа юм. Словак улсын ерөнхийлөгч Монгол Улсын ерөнхийлөгчтэй эрх мэдлийн хувьд бараг адилхан гэж хэлж болно. Гүйцэтгэх засаглал нь Засгийн газартаа байдаг, Монгол Улсын Засгийн газартай бараг адилхан. Ерөнхийдөө ийм. Словак улс нь 1993 онд тусгаар улс болсноосоо хойш гадаад бодлогоо ЕХ-д ороход чиглүүлж, 2004-5-1-нд ЕХ-ны жинхэнэ гишүүн болсон. Монгол-Словакийн хоорондох харилцааны хувьд гэвэл анх Словак улс тусгаар улс болоход 1993-1-1-нээс 1993-9-30-ны өдөр хүртэл Улаанбаатар хотод Словак улсын Хэргийг түр хамаарагчийн хэмжээнд хуучин холбооны улсын тусгаар улс болохтой холбогдсон өмч хөрөнгийн асуудлыг зохицуулах зориулалттайгаар энд байгаад, дараагаар 2000-11-30-нд Бээжин дэх ЭСЯ-ны харьяалалтай Улаанбаатар хотод Өргөмжит консулынхаа газрыг нээсэн.

Өргөмжит Консулын хувьд бол гол үйл ажиллагаагаа хоёр орны хамтын ажиллагааг өргөжүүлэх, консулын үүрэгт ажлыг гүйцэтгэх, хоёр улсын байгууллага, иргэдийг мэдээллээр хангахад чиглэгдэж байгаа. Ерөнхийдөө Словак улсын хөгжлийн талаар яривал аж үйлдвэрийн орон, голлон ашигт малтмалын олборлолт, хөнгөн ба хүнсний үйлдвэрлэл, цаас

ба химийн үйлдвэрүүд голчлон байдаг. Экспортын гол орнууд бол Европын Холбооны орнууд. 60 орчим хувийг ЕХ-д экспортлодог, 2-р байранд Чех Улс ордог юм. Импортын түншүүд нь бас л ЕХ-ны орнууд 50 орчим хувь, 15% нь Чех Улс, 14% нь ОХУ. ДНБ-ний хэмжээ жилд ойролцоогоор нийт 4% байгаа, үүний 88%-ийг хувийн хэвшлийнхэн эзэлж байгаа юм. Словак улс ЕХ-ны улс болсноор Монгол Улсад хөгжлийн тусламж үзүүлж эхэлсэн. Словак улсын хөгжлийн тусламж үзүүлдэг 8 орны нэг нь Монгол Улс юм. Одоогоор геологи, ХАА-н салбарт 3 төсөл хэрэгжиж байгаа. Энэ тусламжийн талаар аль аль талдаа өргөжүүлэх бололцоотой гэж бид нар үзэж байгаа юм.

Хурлын дарга: Баярлалаа. Одоо Монголын Энх тайван, найрамдлын байгууллагуудын холбооны ерөнхий захирал Билэгт гуайг урьж байна.

Билэгт: Юуны өмнө, Польш, Болгар, Унгар, Чех, Словак, Румын улстай дипломат харилцаа тогтоосны 55 жилийн ойд зориулан зохион байгуулж буй энэ дугуй ширээний хуралд миний биеийг урьж оролцуулсанд талархал илэрхийлэхийн хамт эдгээр улсуудаас суугаа эрхэмсэг ноён Элчин сайд, ӨК нарт энэ ойн баярыг тохиолдуулан халуун мэнд дэвшүүлье. Энэ үйл явдалтай холбогдуулаад илтгэгч хатагтай Оюунгэрэл болон Элчин сайд нар, ӨК нар манай орнуудын хоорондын улс төр, эдийн засаг бусад харилцааны түүх, өнөөгийн байдлын талаар тодорхой, сайхан ярьсанд зүй ёсоор миний хувьд ч гэсэн, бусад нөхдүүдийн хувьд ч сонирхолтой мэдээлэл болсон гэж бодож байна. Өнгөрсөн зууны 50-иад онуудад эдгээр орнуудтай тогтоосон дипломат харилцаа бол XX зууны II хагаст бусад орнуудтай тогтоосон харилцаа төдийгүй, олон улсын харилцаанд чухал үүрэг гүйцэтгэсэн үйл явдал болсон гэж би үзэж байна. Энэ дипломат харилцаа тогтоосноос хойш манай хоёр орнуудын улс төр, худалдаа-эдийн засаг, соёл, боловсрол зэрэг бүхий л салбарт түүний дотор олон нийтийн салбаруудын харилцаа, холбоо бас тогтож, хөгжиж, өргөжиж ирсэн. Би үүнийг юутай холбогдуулж ярих гэж байна гэвэл, 50-иад оны дунд үеэс эдгээр орнуудтай найрамдах, найрамдлын нийгэмлэгүүд манай оронд байгуулагдаж эхэлсэн. Монгол-Болгарын, Монгол-Унгарын, Монгол-Чехословакийн, Монгол-Румыний найрамдлын нийгэмлэгүүд ойрхон хугацаанд байгуулагдсан байгаа. Эдгээр нийгэмлэгүүд бол тухайн орнуудтай харилцаж байсан харилцаанд олон нийтийн шугамаар харилцах чиглэлээр байгуулагдаж, хоёр орны найрамдалт харилцаа, ард түмнүүдийн харилцааг хөгжүүлэх, өргөжүүлэх ийм харилцаа

явагдаж байсан. Тухайн үедээ манай нам, төр засгаас эдгээр орнуудтай харилцах найрамдалт харилцаанд чухал ач холбогдол өгч байсан учраас эдгээр найрамдлын нийгэмлэгүүдийг манай төр засгийн хүмүүс, яамдын сайд, тусгай газрын дарга нар, соёл, урлагийн том том зүтгэлтнүүд эдгээр нийгэмлэгүүдийг тэргүүлж ирсэн. Мөн үүнийг дагалдан тухайн орнуудад манай оронтой найрамдах нийгэмлэгүүд бас байгуулагдаж байсан. Монголтой найрамдах нийгэмлэгүүд бүгдэд нь байсан. Мэдээж Словак улс сүүлд байгуулагдсан учраас Словакийн нийгэмлэг 1990-ээд оны дундаас байгуулагдсан. Эдгээр найрамдлын нийгэмлэгүүд байгуулагдаж эхэлснээс хойш хоёр орны хоорондох найрамдалт харилцаанд хувь нэмэр оруулах үүднээс төрөл бүрийн арга хэмжээнүүд зохиогддог байсан. Хоёр орны харилцааны түүхтэй холбоотой ой, түүний дотор дипломат харилцааны ойг, тэгш ойннуудыг буюу бусад ойннуудыг өргөн тэмдэглэж байсан. Энэ үеэр янз бүрийн арга хэмжээнүүдийг зохиодог, үзэсгэлэн гаргах, уулзалт, үдэшлэг, баярын хурал хийх, эрдэм шинжилгээний хурал, сургууль төгсөгчдийн уулзалт хийдэг байсан. Мөн үүний хүрээнд төлөөлөгчдийг харилцан өргөн солилцдог байсан. Зарим орнуудад соёлын өдрүүдийг зохиож ирсэн. Энд манай орон өргөн оролцдог байсан. Үүгээр зогсохгүй мөн найрамдлын нэрэмжит ХАА-н нэгдлүүд байгуулагдаж байсан. Жишээлбэл, Монгол-Польшийн төв аймгийн Баян сум, Монгол-Унгарын Эрдэнэ сум гэх мэт найрамдлын гишүүнд гишүүн байгууллагууд олноороо байдаг байсан. Тухайн орнуудтай эдийн засгийн харилцааны шугамаар байгуулагдсан үйлдвэр, аж ахуйн газрууд нь тухайн нийгэмлэгүүдийн найрамдлын гишүүн байгууллагууд байдаг байсан. 1980-аад оны сүүл 1990-ээд оны эхэн үед өргөн хүрээтэй явагдаж байснаа тухайн улс төр, ардчиллын шинэ уур амьсгалтай улс орнууд зах зээлийн эдийн засагт шилжсэнээр энэ нийгэмлэгүүдийн үйл ажиллагаа тодорхой шалтгаанаар зогссон хэдий ч манай олон түмний дотор энэ найрамдалт харилцааг үргэлжлүүлэх, сэргээх, дахин нийгэмлэгүүдийг байгуулах хөдөлгөөн өрнөсөн. Ялангуяа, тухайн орнуудад сургууль төгссөн, ажиллаж байсан хүмүүс маш идэвхтэй оролцож, энэ нийгэмлэгүүд дотроос Польш, Болгар, Чехословак, Румыний нийгэмлэгүүд 1990-ээд оны эхний хагаст шинэчлэгдэж, сэргээж байгуулагдаж эхэлсэн. 1993 оноос Словакийн нийгэмлэг гэж бий болсон. Гол төлөв энд тухайн тогтолцооноос болоод тодорхой хүнээс хараат байсан бол ерөөсөө нам, засаг, төрөөс хамааралгүйгээр жинхэнэ сайн дурын үндсэн дээр бие даан үйл ажиллагааг явуулдаг нийгэмлэгүүд болж гарч ирсэн.

Хэдийгээр эдгээр нийгэмлэгүүд нь санхүү, эдийн засгийн болон бусад зохион байгуулалтын дорой байдлаас болж идэвхтэй үйл ажиллагааг явуулж чадахгүй байгаа ч гэсэн тухайн орнуудтай харилцах чиглэлээр их анхаарч ажиллаж байгаа. Би түрүүн дээр тэмдэглэсэн, сургууль төгсөгчид их идэвхтэй ажиллаж байгаа. Мөн эдгээр Польш, Болгар, Унгар, Чехословак, Румынд байсан хуучин түнш нийгэмлэгүүд нь бас байхгүй болсон учраас нилээд хүндрэлтэй байсан. Сүүлийн үед Польш, Болгарт Монголтой харилцах нийгэмлэгүүд шинээр сэргээгдэж бий болсон байна. Ялангуяа үүний дотор Польшийн нийгэмлэгийг онцлож хэлмээр байна. Польш-Монголын нийгэмлэг байгуулагдснаасаа хойш манай Монгол-Польшийн нийгэмлэгтэй холбоо тогтоож хамтран ажиллаж байгаа. Манайд зудын гамшиг тохиолдох үеэр Польш-Монголын хамтын нийгэмлэг 15 мянган ам.долларын хандив өгсөн. Эл хандиваа тус нийгэмлэгийн дарга, төлөөлөгчид Улаанбаатарт ирж ЭСЯ дээр ирж хүлээлгэж өгсөн байгаа. Энэ бол их чухал. Түүнээс гадна янз бүрийн эм, эмийн болон бусад зүйлээр тусламж үзүүлж байсан. Польшд төгсөгчид идэвхтэй ажилладаг. Төгсөгчдийн уулзалтыг тогтмол зохиодог. Ялангуяа, Польшоос ирж байгаа Сеймын бусад засаг, төрийн төлөөлөгчдийг ирэхэд уулзаж бараалхах, өөрсдийгөө танилцуулах арга хэмжээнүүдийг зохион байгуулдаг. Унгарын сургууль төгсөгчид ч гэсэн бас идэвхтэй, өөрсдийн жижиг клубтай, ЭСЯ-тай бас холбоотой ажилладаг. Чехийн найрамдлын нийгэмлэг ажиллаж байгаа. Бас л зохих чармайлт, идэвхи гаргадаг юм. Эдгээр орнуудаас Элчин сайдуудад хүсэлт тавих юм гэвэл энэ жил манай Монголын Энх тайван, найрамдлын байгууллагуудын холбоо нь Дорнод Европын орнуудаас хуучин харилцаж байсан орнуудад харилцах түнш байгууллагуудтай танилцуулах, дэмжлэг тусалцаа үзүүлнэ үү гэж хэлмээр байна. Болж өгвөл энэ жил эдгээр орны холбогдох байгууллагуудтай холбоо тогтоох зорилгоор хамтарсан төлөөлөгчдийг илгээж, энэ найрамдлын нийгэмлэгүүдтэй харилцах харилцааг сэргээх, хамтын ажиллагааг хэрэгжүүлэх чиглэлээр төлөөлөгчдийг явуулахаар бодож байгаа юм. Энэ ажил дээр эрхэмсэг ноён элчин сайдууд бас дэмжлэг, тусалцаа үзүүлэхийг хүсч байна.

Хурлын дарга: Билэгт-гуайд баярлалаа. Одоо асуулт, хариултдаа орьё. Илтгэл тавьсан хүмүүс болон Элчин сайд нараас асуух зүйл байна уу?

Удвал: Одоогийн нөхцлөөр тоо, баримт байна уу? Монголд аль зэрэг цар хүрээтэй гэдгийг мэдэх гээд байна л даа.

Билэгт: Түрүүн тэмдэглэснээр, 1990-ээд оны хувьд тодорхой шалтгаанаар хязгаарласан байсан. 1997 онд ТББ-ын тухай хууль гарснаас хойш эдгээр байгууллагууд Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгэгдэж хуулийн этгээд болцгоосон. Цар хүрээгээ өргөтгөх асуудал дээр гол нь санхүүгийн бэрхшээл юм. Мэдээж сайн дурын үндсэн дээр хувь хүмүүс нийлж ажиллаж байгаа учраас санхүүгийн бэрхшээлтэй болохоор үйл ажиллагааны цар хүрээ хязгаарлагдмал. Миний дахиад давтаж хэлээд байгаа зүйл бол нилээд идэвхтэй оролцдог. Тэдгээр улсууд хэдийгээр өргөн хүрээтэй үйл ажиллагаа явууль ч гэсэн, санхүүгийн бэрхшээлтэй тулгардаг. Энэ талаас ЭСЯ-дуудаас тодорхой хэмжээгээр тусалдаг хүмүүс бий. Цаашдаа цаад талдаа түнш байгуулах нь чухал, яагаад гэвэл харилцаа бол өөрөө хоёр тал оролцож байж үйл ажиллагаа явагддаг. Иймээс ноён Элчин сайдуудаас хүсээд байгаа зүйл түнш байгууллага олж өгөх, дэмжлэг үзүүлэхийг хүсч байна. Гишүүнчлэлийн хувьд гэвэл, тодорхой баримт алга байна. Гол төлөв төгсөгчдөөс бүрэлддэг.

Буянтөгс /ОУСХ/: Юуны өмнө, дипломат харилцаа тогтоосны ойн баярыг тохиолдуулан бүх ноён Элчин сайдуудад баяр хүргэж, та нарт бүгдэд нь асуулт тавих гэсэн юм. Та нарын үзэж буйгаар ирээдүйд манай хамтын ажиллагааг ямар салбарт хөгжүүлэх илүү бололцоотой вэ? Танай орнууд үйл ажиллагаагаа Европын Холбоонд орсноор Ази дахь оролцоо багасаж, Монголтой харилцах харилцаанд ямар нэгэн квот бий болох уу? Европ руу илүү чиглэх үү?

Унгарын Элчин сайд: Миний бодлоор, харин ЕХ-д элсэн орсноор манай хоёр орны харилцаа улам өргөжихөд бүрэн нөхцөл бүрдэнэ гэдэгт итгэлтэй байна. Энэ бол тодорхой. Энд мэргэжил нэгтнүүд сууж байна. Бид нар санал нэгтэй гэдгээ хэлмээр байна. Энэ нь харилцааг өргөтгөж өгнө. Юуны түрүүнд, эдийн засгийн хамтын ажиллагаа. Сүүлийн 3 жилийн дотор манай экспорт 3 дахин өссөн. Харилцан бизнес эрхлэгчдийн сонирхол маш ихээр өсч байна гэж хэлж болно. Манайд хэрэгжиж байгаа Asia Invest ALA программын хүрээнд илүү их санхүүгийн бололцоо нээгдэнэ гэсэн үг. Энэ нь нэгдүгээрт, хувийн компаниудын хувьд ашигтай. Одоогоор Европт нэгдмэл зах зээлтэй байна. Та нар Европт очихдоо гааль гэдэг байхгүй гэдгийг харсан байх, гааль гэдэг үг ч хэрэглээнээс гарсан байна. Хил дээр татвар үлдээд, гаалийн бүх ажилтнуудыг ажлаас чөлөөж, мэргэжлийг нь сольж, зарим нь эрт тэтгэвэрт гарсан. Яагаад гэвэл энэ мэргэжлээр ажил олоход хэцүү, зөвхөн Румын, Украины хил дээр гааль ажиллаж болно. Румын

ч удахгүй ЕХ-д орох гэж байна. Энэ бол нэг жишээ. Соёлын салбарт ч гэсэн мөн адил. Ирээдүйд илүү их арга хэмжээ зохиогдох болно. Бид нар ЕХ-д орсноор манай орнуудын харилцаанд ер нь эерэг үр дүн гарна. Монголын хувьд ч гэсэн мөн адил. Танай орны хувьд интеграцийн өргөн хүрээний зохион байгуулалтад хуучин дотно найзууд бий – Польш, Болгар, Чех, Унгар, Словак, Унгар гэх мэт.

Миний мэргэжил нэгт нөхөд хүний хүчин зүйлийн тухай, 55 жилийн хамтын ажиллагааны тухай ярилаа. Тэгэхээр хэдэн зуу гаруй монголчууд манайд төрөл бүрийн сургуулиуд, их сургуулиудад суралцсан. Миний дээр дурдсанчлан хэдэн зуун монголчууд Чех юмуу Унгарт оёдлын үйлдвэрт ажиллаж байна. Унгарын зарим оёдлын үйлдвэрүүд зөвхөн Монголын ажиллах хүчний тусламжтайгаар л оршин тогтнож байна. Эсрэг тохиолдолд ажиллах хүч хүрэлцэхгүйн улмаас тэд зүгээр л дампуурчих байсан. Эдгээр үйлдвэрүүдэд гадаадын эрэгтэй, эмэгтэй хүмүүс ажиллаж байна.

Олон мянган унгарчууд энд урт хугацаагаар ажиллаж байсан, олон зуун гэрлэлт болж байсан, энэ гэрлэлтийн дүнд олон зуун бараг мянга гэж хэлж болох хүүхдүүд бий.

Энэ бол манай хоёр улсыг үүрд маш найдвартайгаар холбож буй маш хүчтэй, найдвартай гүүр юм. Манай улсын Монгол руу чиглэсэн экспорт, Монголыг сонирхож буй сонирхол, хөрөнгө оруулалт, хамтарсан үйлдвэр байгуулах сонирхол өсч буй явдал нь юуны өмнө хүний хүчин зүйл, Унгарт сурч байсан хүмүүс, Чех, Польшид сурч байсан хүмүүсийн холбоонд ажиллаж буй хүмүүсийн, мөн эдгээр найрамдлын нийгэмлэгийн ач тус юм. Жишээлбэл миний мэдэх манай найрамдлын нийгэмлэг татвар төлдөг, төрөл бүрийн үйл ажиллагаанд зориулан хөрөнгө мөнгө цуглуулдаг 450 гишүүнтэй бөгөөд сар болгон над дээр ямар нэгэн зүйл хийх саналтай ирдэг. Зарим санал нь сонсоход бүр гайхмаар байдаг бөгөөд эдгээр сонсож буй санаанууд хэзээ ч миний толгойнд орж ирэхгүй байх байсан биз ээ. Энэ нь их гайхамшигтай саналууд байдаг бөгөөд шууд л Унгар луу хэн нэгэн рүү санал болгож, хамтрагч хайж, ойлгож эхэлдэг. Энэ саналуудын ачаар жишээлбэл Унгарт суралцаж байсан хүмүүсийн нийгэмлэг, найрамдлын нийгэмлэгийн ачаар энэ жилд төлөвлөгдсөн байсан соёлын арга хэмжээний тоо гурав дахин өссөн. Тэгэхээр 3 биш 9 арга хэмжээ явагдах нь. Гэхдээ энэ нь засгийн газрын мөнгөөр биш бөгөөд бид хөрөнгө мөнгө цуглуулж, нөөц үүсвэр зэргийг олох болно. Миний бодлоор манай ашиг сонирхол их эрчтэй өсч байгаа бөгөөд би Европын Холбоонд

сайшаагдсан Азийн бодлого байгаа гэж хэлмээр байна. Энэ Европын Холбооны жишээгээр манай улсын Засгийн газар өнгөрсөн жил Европын Холбоонд элсэн орсныхоо дараа манай үндэсний Азийн бодлогыг сайшаасан. Унгарын шинэ Азийн бодлогын үр дүнд сүүлийн хэдэн сарын хугацаанд манай Ерөнхий сайд хэд хэдэн Азийн оронд айлчилсан, манай сайд Азийн хэдэн орноор айлчилж байгаа, манай хууль зүйн яамны сайд бас 6 сарын 7-нд наашаа ирэхээр бэлтгэж байгаа. Будапешт хотын дарга бас наашаа Улаанбаатар хоттой харилцаа тогтоохоор ирнэ.

Чехийн Элчин сайд: Ноён Михайн хэлсэн дээр би нэг л юм нэмье. Манай 4 улсыг Европын Холбоонд элсүүлснээр (энэ нь цаг хугацааны л асуудал) Европын Холбоонд Монголыг дэмжих төлөөлөгчдийн тоо өснө.

Хоёрдугаарт: бид энэ хуучин гишүүдээс илүүгээр Монголын асуудлыг ойлгодог. Энэ шилжилтийн үеийг, учир нь бид ч мөн адил энэ үеийг дайрч гарсан. Тэдэнд их амархан юм шиг санагдаж байгаа ч бид зөвхөн хууль тогтоох биш өөрсдийгөө өөрчлөх (толгойгоо өөрчлөх) хэрэгтэй. Энэ бол маш түвэгтэй зүйл. Энэ дээр бид Монголд, энэ нөхцөл байдлыг ойлгоход нь тусална. Би өдийг хүртэл Европын Холбоо бага юм хийсэн гэж боддог. Та нар удахгүй бидний хүчээр нөхцөл байдал бага зэрэг сайжрахыг харах болно. Бидний энэ Европын холбоонд элссэн явдал нь Монголын хувьд ашигтай юм.

Польшийн элчин сайд: Миний бодлоор өргөн хүрээгээр хамгийн гол нь эдийн засгийн сонирхлын хэвийн нөхцөл нь Монголын хувьд Ази, Польшийн хувьд Европ юм. Манай улсын хувьд нийт барааны эргэлтийн 70-аас илүү хувь Европтой хийж буй бараа эргэлт юм. Тэгээд үүн дээр АНУ, Ойрхи Дорнод нэмэгдэнэ, үнэндээ бол Азийн хувьд нэг их юм үлдэхгүй. Бид энэ 50 жилийн хугацаанд Төв Европын сургуулиудад суралцсан олон зуун, бүр олон мянган гэж хэлж болох монголчуудын тухай ярьж байна. Гэтэл өнөөдөр зөвхөн БНСУ-д хорин мянган монголчууд ажиллаж, амьдарч байна. Намайг 4 жилийн өмнө энд ирж байхад миний санаж байгаагаар Монголд үйлдвэрлэсэн, уутанд савласан кимчи дэлгүүрт байдаггүй байсан. Харин өнөөдөр бол байна, гэхдээ энэ нь солонгосчуудад биш Өмнөд Солонгост байхдаа кимчинд дуртай болсон монголчуудад зориулсан юм.

Хятад бол Монголын хамгийн том худалдааны түнш юм. Монголын бараг бүх экспорт гардаг орон юм. Япон бол Монголын хамгийн том хандивлагч орон, тэгэхээр бараг Монголтой хамтран ажиллана гэдэг бол Азитай хамтран ажиллана гэсэн үг, учир нь Монгол бол Азийн

орон юм. Харин бидний дөрвөн орон бол Европын орнууд. Мэдээж хамтран ажиллах хэрэгтэй. Миний өмнөх мэргэжил нэгт нөхдүүдийн ярьсанчлан Европын Холбоо өнөөдөр дөрвөн шинэ гишүүнээр өргөжинө. Энэ нь Монгол, Европын Холбооны худалдааны харилцаанд нэмэр болох болно. Бид маш хол газар зүйн зайд оршиж байгаа, Монголын хувьд байгалийн хүрээлэл нь Ази гэдэг хэвийн нөхцөл байдлыг өөрчлөхгүй юм. Бид нарын хувьд энэ нь Европ юм.

Мөнх-Очир /Стратеги судлалын хүрээлэн/: Европын Холбоонд эдгээр 4 орон элссэнтэй холбоотойгоор үүсэх асуудлын талаар бид ярилцаж байна. Эдгээр орнууд нь бүгд НАТО-гийн гишүүд болшгоосон. Монгол Улс НАТО-гийн “Энхийн төлөө түншлэл”-д нэгдэн орох хүсэлтээ илэрхийлсэн. Энэ чиглэлээр дэмжлэг авах хамгийн бодитой түншүүд маань бидний энэ хүсэлтийг ойлгох хамгийн боломжтой улсууд маань энэ хэдэн улсууд гэж ойлгогдож байгаа. Тийм учраас энд дэмжлэг үзүүлнэ биз дээ, ямар ямар дэмжлэг үзүүлэх вэ? гэдэг ерөнхий асуулт элчин сайд нарт хандаж тавих гэсэн юм.

Хоёрдугаарт нь Оюунгэрэл докторт хандаж асуулт тавих гэсэн юм. Гадаад хэргийн яамны хүмүүст ч бас хамаарах байх. Бид энэ бодлогынхоо албан ёсны баримт бичигт бас хэтэрхий баригдчаад байгаа юм биш биз дээ. 1994 онд батлагдсан “Гадаад бодлогын үзэл баримтлал”-д тусгагдсан гадаад бодлогын чиглэлийн эрэмбүүд байж байгаа. Нилээн хойгуур уламжлалт харилцаа бүхий хуучин социалист орнууд, Төв болон Зүүн Европын орнууд байгаа. Гэтэл 2-р чиглэлд маань өндөр хөгжилтэй баруун Европын орнууд гэсэн категори орчихсон явж байдаг. Бүх үзүүлэлтээр харах юм бол тэр нэгдэн орсон байгууллагынхаа зүгээс ч гэсэн өнөөдөр хүрчээд байгаа тэр эдийн засгийн үзүүлэлтүүдээрээ ч гэсэн эдгээр улсууд өндөр хөгжилтэй баруун Европын орон гэдэг тэр газар зүйн биш ойлголтонд нийцэх болчихоод байгаа шүү дээ. Тэгэхээр бид өнөөдөр тэр 94 оньхоороо энэ харилцаанд хандаж болж байгаа юм уу? гэж асуух байна.

Хурлын дарга: Таны эхний асуулт элчин сайд нарт хандаж тавьсан байна. Тэгэхээр элчин сайд нар хариулах байх. Мөн түүнчлэн өнөөдрийн уулзалтанд манай ГХЯ-ны Европын газрын захирал Батсуурь оролцож байгаа. Таны хоёр дахь асуултанд элчин сайд нар хариулсаны дараа хариулах байх.

Чехийн Элчин сайд: Би энэ асуулт бол Европын Холбоо гэдгээс хамаагүй өөр гэдгийг хэлмээр байна. Энэ нь өөрийн хүрээ, үйл ажиллагаатай юм. Монгол нь өнөөдөр “Энхийн төлөө түншлэл”-ийн

түнш байхыг хүсэж байгаа гэдгийг уншсан. Би танай ГХЯ-ны сайдын хамгийн гол нь олон бүс нутгуудад НАТО-гийн орнуудтай даалгавараа амжилттай биелүүлж буй танай энхийг сахиулах хүчинд стандарт олохыг зорьж байна гэсэн тайлбарыг сонссон. Ийм учраас би ямар ч тохиолдолд энэ түншлэлийг дэмжиж байна. Тэгээд бидэнд сайдын тайлбарласан хүрээнд бол асуудал байхгүй гэж бодож байна.

Унгарын Элчин сайд: Миний мэдэж байгаагаар Унгарын талаас бас энэ НАТО-гийн түншлэлийг дэмжиж байгаа. Унгар-Монголын хооронд дипломат харилцаа тогтоосны энэ ойн баяраар манай удирдагч нараас ирүүлсэн мэндчилгээнд энэ талаар бас бичсэн байна. НАТО-гийн түншлэлийг манай тал дэмжиж байна гэж бичсэн байна.

Батсуурь: Гадаад бодлогын үзэл баримтлалыг эргэж харах, тодорхой хэмжээний өөрчлөлт оруулах цаг болсон тухай бид ярьж байгаа. Энэ талаар манай яам бол ажиллаж байгаа. Гэхдээ нэмж хэлэхэд 1994 оны үзэл баримтлал нь эдгээр улстай харилцан хамтын ажиллагаа хөгжүүлэхэд ямар нэгэн саад болохгүй. Бид харилцан хамтын ажиллагаа хөгжүүлэх талаар болоцоотой бүхнийг хийж байгаа.

Лхагважав /"Урбанек" компанийн захирал/: Европын холбоонд байгаа манай хуучин түнш улсууд маань Монголын тухай лобби, Монголын тухай асуудал Европын холбоонд ороход Монголын талаар лобби, дэмжих тал дээр тийм бүлэг байгуулагдсан болов уу? Тийм лобби бүлэг талаасаа ханддаг болов уу? Гэхдээ нэгдэх тал дээр. Эдийн засгийн бизнесийн хувьд бид тархай байдаг тэр цэг маань нэг болчихоод байгаа, одоо бид нар энд нэгдсэн бодлогоор явах уу?

Польшийн элчин сайд: Бидэнд тийм байгууллага байгаа. Ер нь бол энэ гишүүд нь энд Монголын нөхдүүдтэйгээ ажилладаг бизнесмэнүүд байдаг байгууллага юм. Нөгөө нэг тийм байгууллага нь бол гишүүд нь голдуу Варшавын их сургуулийн Монгол хэл, соёлын факультетийн оюутнууд юм. Үүний дээр ноён Лхагважав маш чухал зүйл хэлсэн гэдгийг хэлмээр байна. Манай хоёр улсын хоёр талт харилцааны хүндрэл (польшийн талаар ярьж байна) бол манай хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоод 55 жил болж байна, бид төрөл бүрийн холбоонд 90-ээд оныг хүртэл хамтдаа байсан, төрөл бүрийн төлөөлөгчид Польшоос Монгол руу, Монголоос Польш руу айлчилж байсан гэхдээ бид бие биенээ сайн мэддэггүй байсан. 2004 онд манай улсын ГХЯ-ны сайд Монголд айлчлахад түүнийг 60 бизнесмэн дагалдаж ирсэн. Тэд ер нь Монголд бизнес эрхэлж болно гэдэгт маш их гайхаж байсан. Тэд зүгээр л үүнийг мэдээгүй юм. Польшийн тухай Монголд, Монголын тухай

Польшид сурталчлах энэ бол маш чухал зүйл юм. Энэ айлчлалын дараа би маш олон e-mail хүлээн авах болсон. Монголд бизнес эрхлэх талаар сонирхсон төрөл бүрийн жижиг, дунд зэргийн, бүр томоохон үйлдвэрүүдээс хүртэл e-mail авсан. Сайд ирсэн учир телевизороор үзүүлсэн, хэвлэлд бичсэн. Тийм учраас энэ талын харилцаанд бидэнд юу дутагдаж байна вэ? гэдэг нь шууд харагдаж байна. Мэдээлэл тэр тусмаа сайн зохион байгуулагдсан мэдээлэл хангалтгүй байсан.

Хурлын дарга: Өөр асуулт тавих, санал бодлоо хэлэх хүн байна уу?

Б.Нямаа /ахмад дипломатч/: Үг хэлэх боломж олгосонд баярлалаа. Өнөөдрийн энэ арга хэмжээ бол Зүүн Европын орнуудтай Монгол Улс албан ёсны харилцаа тогтоосны ойд зориулагдаж байгаад би баяртай байна. Нэр томъёоны хувьд Зүүн Европ гэж одоо ярьж байна, 50-иад онд бол ардчилсан орнууд гэж ярьж байсан. Тэр ардчилсан орон гэдэг бол тухайн үедээ тодорхой зүйлийг хэлж байсан. Дайны дараа Зүүн Европын орнууд бол сэргээн босголтын ажлыг явуулж байсан. Ардчиллын талаар ч гэсэн эдийн засгийн талаар ч гэсэн нийгмийн талаар ч гэсэн. Энэ ардчилсан улсуудтай тогтоосон Монголын харилцаа бол Монгол Улсыг түгжигдмэл байдлаас гаргахад томоохон ахиц өгсөн улс төрийн ихээхэн ач холбогдолтой алхам байсан юм. Зүүн Европын орнуудад бид яагаад хандсан гэхээр бид дэлхий рүү гарах, дэлхий дахинтай холбоо тогтооход бол хамгийн анхны том замыг зааж өгсөн. Хоёрдугаарт: Зүүн Европын тэр ардчилсан орнууд бидэнд наашаа харж, харилцаа тогтоох, бидэнд туслахыг эрмэлзэж байсан ийм улсууд байгаа юм. Үүгээрээ онцлогтой. Би Чех улсад сурч, ажиллаж, амьдарч байсан болохоор Чехийн талаар бусад орныг бодвол арай ойр мэднэ. Одоо нэр томъёонд орьё. Энд судлаачид их олон хүн байх шиг байна. Чехословак улс задарсны дараа гэж ярьж байна. Задрал гэж ярьж байна. Үүнийг монгол нэр томъёонд оруулж засах ёстой байх. Задрана гэдэг чинь хүчээр юм уу өөр хүчний нөлөөгөөр бий болсон зүйл байж болно. Энд Чех, Словак улсуудын тусгаар тогтнол гэж ярьж байх ёстой байх гэж бодож байна. Задрал гэдэг бол чехээр “ороспат” гэж ярьдаг байх, тусгаар тогтнол гэдэг бол “осомастнение” гэж ярьдаг байх. Тэгэхээр энд бол ялгаа бий. Үүнийг бичих, бусдад тайлбарлахдаа бодуштай зүйл юм уу гэж бодож байна. Харилцаа, хамтын ажиллагааны хувьд Зүүн Европын орнууд бидэнд их зүйл өгснийг та бүгд ярилаа, элчин сайдууд ярилаа, ном зохиолуудад ч бичээстэй байгаа. Энэ талаар тодорхой дүгнэлтүүд хийгдсэн, тэр үндсэн дээр суурилж одоогийн шинэ харилцаа хөгжиж, өсч байна гэж үзэж байна.

Цаашдаа бид хамтын ажиллагааг хөгжүүлэхэд цаг үеийн шинэ нөхцөл боломжид уялдуулан шинэ шинэ асуудлууд гарч ирж байна гэж бодож байна. Зүүн Европын орнууд одоо Европын Холбоонд элсч байна. Нилээд нь элсчихлээ, үүнтэй холбоотойгоор Монгол эдгээр орнуудын харилцаанд шинэ шинэ зүйлүүд гарч байгаа. Эдгээр орнуудтай харилцахад бид Европ руу хандсан бодлогоо өшөө сайн гүнзгий бодож явуулах шаардлагатай байх шиг байна. Энд улс төрийн харилцаа, эдийн засгийн харилцаа, төрийн шугамаар, төрийн бус байгууллагуудын шугамаар, иргэд ард түмнийхээ шугамаар гэж дотор нь хуваарилах юм бол төрийн болон төрийн бус байгууллагуудын шугамаар харилцаа хөгжиж байна. Хүмүүсийн хоорондын харилцааг хөгжүүлэхэд бид илүү их анхаарах ёстой гэж бодож байна. Ер нь хүнээр дамжиж л бидний харилцаа явагддаг. 1950 онд дипломат харилцаа тогтоосны дараа эдгээр улсуудтай харилцахдаа хүнээр дамжиж харьцсан. Олон хүнээ явуулж сургасан. Их дээд сургуулиудаас нь эрдэм номтой хүмүүсээ ирүүлж харилцаа хөгжүүлэх суурь дэвсгэрийг нь бодитой болгосон. Би өөрөө Карлын их сургуульд анхны 5 оюутны нэгэнд 1955 онд явж байсан. Одоо миний сургуульд явсны 50 жилийн ой болж байна. Энэ жил бол би их баяртай байна. Энэ онд бас харилцаа тогтоосны 55 жилийн ой болж байгаад баяртай байна. Тэгэхээр хүнээр дамжиж бүх харилцаа хөгждөг учраас Европын орнууд руу бид хүнээрээ дамжиж харилцаж байх, тэгэхээр албан ёсны харилцаанаас гадна иргэд хоорондын харилцааг өргөн хөгжүүлэх шаардлагатай байна гэж бодож байна. Энэ дээр консулын алба, тэнд байгаа элчин сайдын яамд, энд байгаа элчин сайдын яамд энэ тал дээр өргөн, их хүлээцтэй, дотно, уужуу тайвуу, учрыг нь олсон, дэмжиж тусалсан ийм харилцааг хөгжүүлээсэй гэж бодож байна. Саяхан уншиж байхад Германы Элчин сайдын яам бол их л хатуурхдаг юм байна. Эрдэмтдийг ч явуулахгүй элдэв юмаар хавчдаг л юм байна. Ийм байдалд манай орнуудын харилцаа бас битгий орчихоосой, үүнийг битгий дууриагаасай харин хуучин уламжлалт харилцаагаа хөгжүүлэхэд дэмжлэг, тусалцаа үзүүлэх талаас нь бодоосой гэж бодож байна. Нэгэнт бүх юм хүнээр дамжиж байгаа учраас хүний харилцааг эн тэргүүнд тавьж хөгжүүлэхийг бүх талаас хүсч байна.

Хурлын дарга: Санал бодлоо хэлсэн ноён элчин сайд танд баярлалаа. Ингээд энэ дипломат харилцаа тогтоосны 55 жилийн ойд зориулж ГХЯ-наас болон Элчин сайдын яамдаас янз бүрийн арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөсөн байгаа. Энэ арга хэмжээний хүрээнд та бүхэн дахин уулзаж учрах, санаа бодлоо солилцох боломж олдох байхаа гэж бодож байна. Ингээд манай өнөөдрийн уулзалт ярилцлагын

цаг нэгэнт дууссан тул энэхүү дугуй ширээний уулзалт, ярилцлагыг хамтран зохион байгуулж байгаа ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэнгийн захирал, доктор, профессор Л.Хайсандай гуайг уулзалтыг хааж үг хэлэхийг урьж байна.

Л.Хайсандай /ОУСХ-ийн захирал/: Баярлалаа, эхлээд хаахынхаа өмнө нэг тайлбар хэлье. Чехословак, Монголын харилцааг хөгжүүлэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн элчин сайд Б.Нямаа судлаачдад хандаж хэллээ. Чех, Словак хоёр задарсан гэсэн үг манай илтгэл болон бидний амнаас гараагүй гэдгийг хэлмээр байна. Одоо хэлээгүй юм чинь цаашдаа ч хэлэхгүй байх. ГХЯ-наас хуучин бол ах дүү гэж нэрлэж байсан орнуудтай дипломат харилцаа тогтоосны 55 жилийн ойд зориулж, олон янзын арга хэмжээ зохион байгуулж байгаа. Одоо “Унгарыг хэн сайн мэдэх вэ”, “Польшийг хэн сайн мэдэх вэ”, “Болгарыг хэн сайн мэдэх вэ”, “Словакийг хэн сайн мэдэх вэ”, “Чехийг хэн сайн мэдэх вэ” гэх мэтийн манай залуучуудын дунд уралдаан тэмцээн янз бүрийн арга хэмжээнүүд зохиогдож байгаа. Өнөөдрийн хувьд энэ олон арга хэмжээний нэг нь манай Олон Улс Судлалын Хүрээлэнгээс зохион байгуулж байгаа энэ дугуй ширээний ярилцлага юм. Манай хүрээлэнгээс эрхлэн жилд 4 удаа гардаг “Олон улс судлал” сэтгүүлийн нэг дугаарыг нь эдгээр орнуудтай дипломат харилцаа тогтоосны 55 жилийн ойд зориулж тусгай дугаар гаргана. Ингээд бидний урилгыг хүлээн авч сайхан үг хэлж, манай хоёр орнуудын хоорондын харилцааны талаар өөрийн санал бодлоо илэрхийлсэн та бүгдэд ШУА-ын ОУСХ-ийн эрдмийн хамт олны өмнөөс мөн манай ГХЯ-ны хамт олны өмнөөс талархал дэвшүүлье. Бидний урилгыг хүлээн авч оролцсон эрдэмтэн, судлаачид, энд оролцсон, үг хэлсэн, асуулт тавьсан бүх хүмүүст талархаж байна. Ингээд та бүгдэд сайн сайхныг хүсье.